

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2019 · 6 сар / Дугаар 8



ГАРЧИГ

3–5 Тогтворжилтын сангийн тогтолцоо, олон улсын туршлага

5–7 Зохицуулалтын мэдээ

8–10 Санхүүгийн зохицуулах хорооны гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.Энхбаатартай уулзаж тус хорооны гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

10–11 Тайлбар ба зөвлөмж

12 Технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хадгаламж, зээлийн хоршооны салбарт / Филиппин улсын туршлагаас/

13 Олон улсын хадгаламж зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөл

14–19 Өргөн дуран

19–20 Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны суурь зарчимд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг тусгасан нь

21–23 Зах зээлийн мэдээ

24 Хадгаламж хамгааллын тогтолцооны олон улсын туршлага

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)–ны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.ЭНХБААТАРТАЙ уулзаж тус хорооны гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

СЗХ–ны гадаад харилцаа өнөөдөр ямар түвшинд байна вэ?

СЗХ бол банк бус санхүүгийн салбарыг бодлого, зохицуулалтаар хангаж ажилладаг байгууллага юм. Бид хөгжлийн бодлого боловсруулахад оролцож, зохицуулалтын стандарт, зарчмууд нэвтрүүлэхэд анхаарч, дагалдах хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг. Товчхондоо, манай хороог санхүүгийн зах зээл дэх шударга өрсөлдөөнийг хангаж, хөрөнгө оруулагч болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалж ажилладаг гэж ойлгож болно. Бид хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ажлыг хяналт шалгалтаар хэрэгжүүлдэг. Ялангуяа олон нийтээс хөрөнгө босгож, бизнесийн төсөлдөө хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжүүд манай байгууллагын анхаарлын төвд байдаг.

СЗХ–ны гадаад харилцааг чиглэлээр тодорхойлж болно. Эхнийх нь санхүүгийн зах зээлийн интеграцид нэгдэх, удаах нь зах

зээлийн чадавхыг сайжруулах юм. СЗХ–ны гадаад харилцааны үндсэн зорилго нь бүс нутгийн болон дэлхийн санхүүгийн зах зээлийн интеграцид гүнзгий орох явдал юм. Интеграц гэдгийг хил хязгааргүй болж байгаа энэ цагт харилцан уялдаатай ажиллаж байгаа, өндөр хөгжсөн болон хөгжиж буй (emerging market) зах зээлүүдийн нэгдэл гэж ойлгож болно. Бид тэр нэгдэл рүү илүү гүнзгий орж тэдний тоглоомд оролцох шаардлагатай юм. Бид өндөр үнэтэй мөнгө хэрэглээд байгаа асуудал ч үүнтэй холбоотой.

Манай зах зээл жижиг, дангаараа хөгжих боломж тун бага, хөгжил нь гадаадын хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай. Тийм учраас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, гаднын хөрөнгийн зах зээлийн гол тоглогчид болох, байгууллагын хэлбэрийн (institutional investor) хөрөнгө оруулагчдыг ажиллах боломж, таатай орчноор хангах асуудлууд чухал юм.

ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СУУРЬ ЗАРЧИМД ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ АСУУДЛЫГ ТУСГАСАН НЬ

2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараагаас санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах асуудал нь санхүүгийн системийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чухал хүчин зүйл болохыг олон улсад хүлээн зөвшөөрч цаашид хөгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байдаг.

Хэрэглэгчийн эрх ашиг хамгаалагдсан байх нь өрх гэр бүлийн түвшинд санхүүгийн бүтээгдэхүүний зардал багасч эрсдэл болон ашиг орлогын талаарх мэдээллийн хүртээмж дээшилж, иргэд олон нийтийн зүгээс санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад итгэх итгэлийг төрүүлж, хадгаламж болон урт хугацааны хөрөнгө оруулалт хийх шалтгаан болдог байна.

Монгол Улсын хэмжээнд одоогоор санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хяналт тавих чиг үүрэгтэй гурван институт ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг банкаас бусад санхүүгийн салбарыг

хянах зохицуулах, тус салбаруудын хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг, Монгол банк нь банкны салбарт тавигдах шаардлагыг хянаж, зохицуулах чиг үүргийг, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар /ШӨХТГ/ нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаа нь өөрийн зохицуулалтанд буй санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байдаг.

Банкнаас бусад санхүүгийн салбар тэр дундаа хадгаламж, зээлийн хоршооны тухайд өвөрмөц онцлогтой бөгөөд гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлдэг ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий бүхий ашгийн төлөө бус байгууллага тул санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллагаас ялгагддаг.



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

Хадгаламж, зээлийн хоршооны хөгжилд гишүүний оролцоо чухал

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн аль ч үед хөдөлмөрийг хорших явдал хэвээр хадгалагдан гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр олон төрлийн хоршооллын хэлбэрүүд бий болж, үйл ажиллагаа нь төлөвшиж, аж ахуйн гол салбаруудад бие даасан томоохон тогтолцоо болтлоо хөгжиж иржээ.

Монгол Улсын хууль тогтоомжоор хоршоо нь түүхий эд боловсруулалтын, үйлдвэрлэлийн, хадгаламж болон зээлийн, борлуулалт, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн, үйлчилгээний, орон сууц барих зориулалтын, эд хэрэглэгчдийн зэрэг үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн байдаг. Хоршоо нь хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг нэгэн зэрэг эрхэлж болох боловч хадгаламж, зээлийн үйл ажиллагааг зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан хоршоо эрхлэхийг зөвшөөрдөг бөгөөд хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн байдлыг тусгай хуулиар зохицуулдаг. Учир нь хадгаламж, зээлийн хоршооны гишүүд нь хоршоонд мөнгөө хадгалуулах, зээл авах үйлчилгээг авдаг боловч өөрсдөө бие даан үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллага болохын хувьд санхүүгийн тайлан мэдээ нь ил тод, аливаа санхүүгийн болзошгүй эрсдэлээс хамгаалах, мэргэжлийн боловсон хүчинтэй байх, эрх бүхий байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөх шаардлагатай тул бусад хоршооноос илүү нарийвчилсан зохицуулалт хэрэгтэй байдаг.

Гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг хадгаламж, зээлийн хоршоо гэж тодорхойлдог. Хадгаламж, зээлийн хоршооны нь анх байгуулагдах цагаасаа эхлэн харилцан туслалцах зарчмаар үйл ажиллагаагаа явуулж өөрийн гишүүдэд санхүүгийн үйлчилгээг хүртэх боломжийг

олгож байдгаараа улс орны санхүүгийн зах зээлд онцгой байрыг эзэлдэг.

Санхүүгийн зах зээлийг бүхэлд нь эсхүл түүний аль нэг сегментыг эзлэх нь хадгаламж, зээлийн хоршооны зорилго биш бөгөөд хувь нийлүүлсэн гишүүдийн байгууллага учир гишүүдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангахыг зорьж, тухайн орон нутгийн болон нийтийн сайн сайхны төлөө ажилладаг.

Монгол Улсын хадгаламж, зээлийн хоршооны тоо санхүүгийн бусад салбарын оролцогчидтой харьцуулахад олон ч санхүүгийн зах зээл дэх хувь нь бага. 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт гишүүдийн тоо 66,296-д хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.9 хувиар өссөн боловч эдийн засгийн идэвхитэй хүн амд харьцуулахад 5.1 хувийг, нийт активын хэмжээ 211.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх үеэс 31.7 хувиар өссөн боловч банкны салбартай харьцуулахад 0.6 хувийг, нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх үеэс 39.8 хувиар өсч 151.0 тэрбум төгрөгт хүрсэн боловч банкны салбартай харьцуулахад 1.2 хувийг эзэлж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн нь өөрөө хувь нийлүүлэгч бөгөөд санхүүгийн үйлчилгээг хүртэгч байдаг. Нөгөөтэйгүүр, хадгаламж, зээлийн хоршоо нь зөвхөн хадгаламж авах болон зээл олгосноор үйл ажиллагаа нь хязгаарлагдах ёсгүй, бусад санхүүгийн байгууллагуудаас хөрөнгийн нэгдэл төдийгүй иргэдийн нэгдэл байдгаараа ялгардаг.

Энэхүү онцлогийг иргэд төдийлөн ойшоодоггүй, хадгаламж, зээлийн хоршооны гишүүний эрх, үүрэг болон хариуцлагын талаар хангалттай мэддэггүй нь ажиглагддаг. Эрх бүхий судалгааны байгууллагаас удаа дараа хийсэн хэрэглэгчдийн итгэлийн судалгаанаас үзэхэд судалгаанд оролцсон иргэд хадгаламж, зээлийн хоршооны талаар ойлголтгүй гэж хариулсан байгаагаас ч энэ нь нотлогддог. Иргэдийн дунд байдаг ерөнхий ойлголтоор хадгаламж, зээлийн

хоршоонд тодорхой хэмжээний хувь нийлүүлж гишүүн болсноор зээл авч болдог байгууллага гэж төсөөлөх нь бий. Иргэд, гишүүдийн санхүүгийн мэдлэг, мэдээллийн хангалтгүй байдал нь хадгаламж, зээлийн хоршоог удирдаж буй этгээдүүдэд харилцан туслалцах зорилготой гишүүдийн дундын санхүүгийн байгууллагын мөн чанарыг эвдэж, ашгийн төлөө бус нийгмийн чиг баримжаатай байх үндсэн зарчмыг алдагдуулж буруугаар ашиглах боломжийг олгодог.

Хадгаламж, зээлийн хоршооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал бөгөөд гишүүн нь оруулсан хөрөнгийн хэмжээнээс үл хамаарч саналын нэг эрхтэй оролцдог орооо ашгийн төлөө үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн байгууллагуудаас онцлог. Бүх гишүүдийн хурлаар тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгож, хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны бодлогыг баталж, хоршоог хөгжүүлэх бодлого, бизнес төлөвлөгөөг баталж, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх зэрэг бүхий л чухал шийдвэрүүдийг гаргаж, гишүүд өөрсдөө хоршоогоо ардчилсан зарчмаар удирдаж, хамтын хяналтыг тавьдаг. Гишүүн нь хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцох үүргийг хүлээхээс гадна хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас учруулсан хохирлыг хувийн өмчөөр хариуцах учиртай.

Иргэд хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны сонгодог утгыг бүрэн гүйцэд ойлгохгүй, гишүүнийхээ бүрэн эрхийг эдэлж чадахгүй зөвхөн өндөр хүүтэй хадгаламж өгөх, хурдан шуурхай зээл авах зорилгоор хадгаламж, зээлийн хоршоонд гишүүнчлэгдэж байгаагаас хоршооны удирдлага анх үүсгэн байгуулсан хэсэг гишүүдийн гарт төвлөрөн, хоршооны үйл ажиллагаа нь эдгээр этгээдүүдийн санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх, ашиг олох арга хэрэгсэл болохоос сэргийлэх хэрэгтэй.

Иймээс хадгаламж, зээлийн хоршоодын засаглалын асуудалд анхаарлыг хандуулж, гишүүдийн идэвхтэй оролцоог бий болгох удирдлагын механизмыг хөгжүүлж, тэдний эрх, үүрэг, хариуцлагын ойлголтын түвшинг нэмэгдүүлэх нь хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийг бууруулахад нэмэртэй гэж үзэж байна.

Энэхүү нийтлэлээр хөндөгдөж буй асуудлаар харилцан яриа өрнүүлэх, үүсээд буй нөхцөл байдалд тохирох хариултыг олох зорилготой бөгөөд салбарын цаашдын хөгжилд саад болж буй асуудлуудыг шийдвэрлэхэд гарц болно гэж үзэж байна.

Нийтлэлд дурдагдсан асуудалтай холбоотой хариулт болон салбарын цаашдын хөгжлийг дэмжихэд чиглэсэн аливаа саналыг хүлээн авахдаа таатай байх болно.

Дунд хугацааны стратеги

1 Үр ашигтай, тэнцвэртэй зах зээлийг бий болгож, эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлнэ.

2 Хоршоодын бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, шинэ нэмэлт үйлчилгээг дэмжих, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн хүртэх бодит үр өгөөжийг өсгөнө.

3 Хадгаламж, зээлийн хоршоодын тогтвортой байдлыг хангах, чадавхжуулахад чиглэсэн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

4 Хадгаламж, зээлийн хоршооны өвөрмөц онцлогийг харгалзан нэгдсэн дэд бүтцийг бий болгон хөгжүүлэх замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

1. Бүртгэлтэй бөгөөд тусгай зөвшөөрөлгүй ХЗХ-дыг цэгцэлнэ

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.2-т “Хадгаламж зээлийн хоршоо улсын бүртгэлд бүртгүүлсэн нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх үндэслэл болохгүй” гэж заасан байдаг. Учир нь уг үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэнэ. Гэвч Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-т “хадгаламж зээлийн хоршоо” буюу “ХЗХ” гэсэн товчлол бүхий статустайгаар бүртгүүлсэн хуулийн этгээдийн тоо Хорооноос тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулж байгаа ХЗХ-дын тооноос ихээхэн давж байгаа юм.

Иймд Хороо УБЕГ-тай хамтран улсын бүртгэлд бүртгүүлсэн атлаа тусгай зөвшөөрөл аваагүй, тусгай зөвшөөрөл авсан ч нэг жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй ХЗХ-дын судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, татан буулгах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргахаар ажиллаж байна.

Хуульд зааснаар УБЕГ-т бүртгүүлсэн ХЗХ ажлын 30 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл

хүсэх өргөдлөө Хороонд гаргах ёстой бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хугацаанд өргөдөл гаргаагүй бол татан буулгах асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх зохицуулалттай. Түүнчлэн тусгай зөвшөөрөлтэй ХЗХ үйл ажиллагаагаа нэг жилийн хугацаагаар эрхлээгүй болон тасалдуулсан бол Хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох бөгөөд хүчингүй болгосноос хойш гурван сарын дотор дахин тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлээгүй, ирүүлсэн ч Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол уг ХЗХ-г татан буулгах үндэслэл бүрдсэнд тооцдог юм.

2. Санхүүгийн зах зээлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад ШӨХТГ-тай хамтарна

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ)-ын дарга Б.Лхагвыг хүлээн авч уулзан, санхүүгийн зах зээлийн харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх чиглэлээр хамтран ажиллахаар ярилцлаа.



Хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийн нэг нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах юм. Иймд Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах нэгжийг байгуулан ажиллаж буйгаа Хорооны дарга С.Даваасүрэн танилцууллаа. Тус нэгж хэрэглэгчдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхийн зэрэгцээ тэдгээрт тулгуурлан санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх зөрчигдөх нийтлэг тохиолдлуудад дүгнэлт хийж, хянан зохицуулах шийдэл, арга замыг тодорхойлж ажилладаг юм.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд давхардал багагүй байдаг ч мөн тэр хэрээр хийдэл цөөнгүй байдгийг Хорооны дарга анхааруулж, тэр бүхнийг арилгах, тус тусын чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд

харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах явдал ихээхэн чухал болохыг онцлон тэмдэглэв. ШӨХТГ-ын дарга хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий зөвлөлийг олон талын оролцоотой байгуулах санал төрийн байгууллагуудад тавьж буйгаа дурдан, уг Зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журмыг Хорооны даргад гардууллаа.

3. Дэлхийн ХЗХ-дыг хамрах Дижитал санхүүгийн хүртээмжийн төсөл Азиас эхэллээ

Дэлхийн хадгаламж зээлийн хоршоодын зөвлөл (ДХЗХЗ, World Council of Credit Unions, WOCUU) Азийн хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дыг дундын нэгдсэн сүлжээнд холбох Дижитал санхүүгийн хүртээмжийн төслийг эхлүүлж, платформуудыг судлан туршиж байна. Төслийг бүсийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэхээр төлөвлөж, эхний ээлжинд Индонез, Филиппин улсын нийт 50 сая гаруй гишүүдтэй томоохон холбоодор дамжуулан эхлүүлээд байгаа бөгөөд нийгэмд нөлөөлөх харилцан уялдаатай, нээлттэй, давтамжтай, өртөг багатай, бодит цагийн төлбөр тооцооны систем болгон хөгжүүлэх зорилт тавьж байна.

“Билл болон Мелинда Гейтс” сангийн дэмжлэгтэйгээр эхлүүлж буй дээрх төслийг “Бүх орон нэг дизайн” зарчмаар хэрэгжүүлэх бөгөөд эхний нэг жилд дижитал төлбөрийн платформ, технологийг боловсруулах, шалгах болон судалгаа төлөвлөлтийг хийж, энэ оны сүүл гэхэд дараагийн үе шатанд буюу бүс нутгийн улс орнуудыг бүхэлд нь хамруулах шатанд шилжих зорилт тавиад байгаа юм. Цаашлаад то-ja-лоор нээлттэй эхэд суурилсан дижитал санхүүгийн платформуыг дэлхийн бүх ХЗХ-дыг хамруулан өргөжүүлэхээр ДХЗХЗ төлөвлөжээ. Тиймд Зөвлөлийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал, ноён Брайн Бренч “дэлхийн санхүүгийн тогтолцоог илүү нягт, нээлттэй, хүртээмжтэй болгоход тусална” гэж төслийн ач холбогдлыг дүгнэн хэлсэн байна.

4. Орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох багш нарт зориулсан сургалт зохион байгууллаа

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголбанк, БСШУСЯ-ны Дундговь, Өмнөговь аймгийн Насан туршийн

боловсролын төв болон Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран эдгээр аймгуудад орон нутгийн иргэдэд санхүүгийн боловсрол олгох сургагч багш нарыг бэлтгэх сургалт зохион байгууллаа. Сургалтад Дундговь аймгийн 19, Өмнөговь аймгийн 24 сургагч багш, Хорооны орон нутгийн төлөөлөгчид, Монголбанкны салбарын ажилтнуудыг хамруулж, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, хөгжлийн хандлагыг танилцуулан, хөрөнгийн болон даатгалын зах зээл, банк ба банк бус санхүүгийн, мөн хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа, тэдгээрийн үндсэн зарчмууд, үл давтагдах шинж чанарууд, онцлог, давуу талуудыг зааж, санхүүгийн суурь мэдлэгийг орон нутгийн иргэд, малчдад хэрхэн олгох, яаж зааж сургах талаар зөвлөв. Нутгийн иргэд ББСБ, ХЗХ-ны салбарыг ихээхэн сонирхохын зэрэгцээ Хорооны зохицуулалтын үйл ажиллагааны талаар мэдэхийг эрмэлзэж байв. Мөн даатгалын давуу талууд, үнэт цаас эзэмших, арилжих болон хөрөнгө оруулалтын боломжуудын талаарх мэдээллийг илүүтэй сонирхож байлаа.

5. Нийслэлийн сургагч багш нарыг сургалтад хамрууллаа

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, БСШУЯ-ны Насан туршийн боловсролын үндэсний төв болон Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран иргэдэд санхүүгийн боловсрол олгох сургагч багш нарыг бэлтгэх цуврал сургалтыг зохион байгуулж байна. Тус сургалтыг нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулж, “Насан туршийн боловсролын үндэсний төв”-үүдийн нийт 21 сургагч багшийг хамрууллаа.



Гурван хоног үргэлжилсэн сургалтаар санхүүгийн боловсрол, түүний агуулга, хэрэглээний тухай ерөнхий ойлголтуудыг багш нарт бататган өгсний зэрэгцээ санхүүгийн зах зээлүүд, тэдгээрийн онцлог, ялгаа, давуу болон сул талууд, мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын бүтэц, зохион

байгуулалт, засаглалын нөхцөл шаардлага зэрэг өргөн хүрээний агуулгыг багтаасан байна. Түүнчлэн санхүүгийн зохицуулалт, үүний шаардлага, арга хэрэгслүүд болон хууль, эрх зүйн орчин, санхүүгийн салбарын эрсдэл, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй танилцууллаа.

Цуврал сургалт үргэлжилсээр байгаа бөгөөд Дорноговь, Говьсүмбэр, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Завхан аймгуудад удахгүй явагдана. Энэ онд нийтдээ 221 сургагч багшийг тус сургалтад хамруулах юм.

6. Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нууцлал

Хуулиар олгогдсон эрхийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо Монгол Улсад Үнэт цаасны зах зээлийн тухай, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчдын тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Зээлийн батлан даалтын сангийн тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай болон холбогдох бусад хуулиудад заасан харилцааг зохицуулдаг. Ингэхдээ эдгээр хуульд заасан үйл ажиллагаа нэг бүрээр дүрэм, журам, заавар батлан мөрдүүлэхийн зэрэгцээ шаардлагатай шалгуур үзүүлэлт болон бусад хэм хэмжээг тогтоон, хэрэгжилтэд нь хяналт тавина.



Дээрх хуулиудад заасан үйл ажиллагааг эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тусгай зөвшөөрөл олгох бөгөөд уг тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтийг хянаж, шаардлага хангахгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох зэргээр зах зээлийн тогтвортой байдлыг хангаж ажилладаг юм. Хорооноос санхүүгийн үйл ажиллагаанд олгож буй тусгай зөвшөөрөл нь төрийн

нэрийн өмнөөс тусгай эрх өгч буй, эрх зүй, зохицуулалтын агууламж бүхий албан ёсны баримт бичиг юм. Өөрөөр хэлбэл, санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр холбогдох дүрэм, журам, заавар, шалгуураар тогтоогдсон хүрээ, хэм хэмжээ, нөхцөл шаардлага тавигдах ба тэдгээрийг мөрдлөг болгон ажиллах нь уг тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрхийг баталгаажуулна.

Иймд тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь тодорхой нууцлал, үл хуулбарлагдах, хуурамчаар үйлдэх боломжийг хязгаарласан шинж чанартайгаар хэвлэгддэг бөгөөд тэдгээр нууцлалаас танилцуулж байна.

7. Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоог чадавхжуулах, хоршоодын дотоод хяналтыг сайжруулах сургалт болов

Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банкаас хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоог чадавхжуулах сургалт боллоо. Сургалтыг АХБ-ны олон улсын зөвлөх Пиер Сегиун, үндэсний зөвлөх Т.Оюунчимэг, СЗХ-ны ажилтнууд удирдан явуулсан бөгөөд хоршоодын төлөөлөл 26 оролцогч хамрагдсан юм.

Сургалтын агуулгад хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийн удирдлага, түүнийг удирдах тухай, хяналтын зөвлөлийн үүрэг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх гэсэн сэдвүүд багтсан ба оролцогчид өөрийн хоршооны сүүлийн дөрвөн жилийн санхүүгийн тайланд шинжилгээ хийж, хэлэлцүүлэг өрнүүлж, харилцан туршлага солилцлоо.

АХБ-ны олон улсын зөвлөх Пиер Сегиун илтгэлдээ ХЗХ-нд тавих хяналт нь юуны өмнө хоршооны өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналт, түүний дараа хяналтын зөвлөлийн дотоод хяналт, хөндлөнгийн аудит, эцэст нь зохицуулагч байгууллагын хяналт гэсэн дарааллаар хэрэгждэг болохыг онцолсон юм.

Хадгаламж, зээлийн хоршоо нь хамтын удирдлага, хяналт бүхий гишүүнчлэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг онцлогтой байгууллага тул дотоод хяналтын үүрэг нэн чухал юм. Тийм учраас нийт хоршооны хяналтын зөвлөлийг чадавхжуулах сургалтыг бүсчилсэн байдлаар үргэлжлүүлэн зохион

байгуулахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна.

Сургалтын явцад СЗХ-ны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах референт Т.Билгүүн “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар мэдээлэл, заавар өгч, оролцогчдын сонирхсон асуултад хариулав.



8. Говийн бүсийн 15 хоршооны хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг сургалтад хамруулав

Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/, Азийн хөгжлийн банк /АХБ/-аас хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд хадгаламж, зээлийн хоршоодын дотоод хяналтыг сайжруулахад чиглэгдсэн сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулж байна. Хадгаламж, зээлийн хоршоодын хяналтын зөвлөлийг чадавхжуулах 2 өдрийн ээлжит сургалтыг Дорноговь аймгийн Сайншанд суманд зохион байгуулж, говийн 4 аймгийг хамрууллаа. Сургалтыг АХБ-ны олон улсын зөвлөх Пиер Сегиун, үндэсний зөвлөх Т.Оюунчимэг, СЗХ-ны албан хаагчид удирдан явуулсан бөгөөд говийн бүсийн 15 хоршооны хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг хамрууллаа.

Сургалтын хөтөлбөрт хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийн удирдлага, түүнийг хэрхэн удирдах, хяналтын зөвлөлийн үүрэг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, санхүүгийн Фина системд тайлан илгээх зааварчилгаа, газар дээрх хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчил дутагдал, анхаарах асуудлууд зэрэг сэдэв багтсан ба оролцогчид өөрийн хоршооны сүүлийн 4 жилийн санхүүгийн тайланд шинжилгээ хийж, тус тусын шинжилгээг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэн харилцан туршлага солилцов.

Хадгаламж, зээлийн хоршоо нь хамтын удирдлага, хяналт бүхий гишүүнчлэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг онцлогтой байгууллага тул дотоод хяналтын үүрэг нэн чухал байдаг. Хоршоодын хяналтын зөвлөлийг чадавхжуулах сургалтыг бүсчилсэн байдлаар үргэлжлүүлэн зохион байгуулах юм. Дараагийн сургалтад төвийн бүсийн хоршоодыг хамруулан ирэх 7 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

9. Хадгаламж зээлийн хоршоодын сонгуульт гишүүдэд сертификат олгох сургалт боллоо

Хорооны 2018 оны 245 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага”-ын 2.1.12-т “ХЗХ-ны тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал нь сонгогдож, томилогдсоноос хойш 6 сарын хугацаанд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх” гэсэн нийтлэг шаардлагын дагуу Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос зохион байгуулсан 2 өдрийн сургалтад 44 сонгуульт гишүүн хамрагдаж, сертификатаа гардаж авлаа.

Сургалтын агуулгад хадгаламж зээлийн хоршооны түүх, онцлог, өнөөгийн байдал, суурь зарчмууд, хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа, хяналтын зөвлөл /тэргүүлэгчдийн зөвлөл/-ийн үйл ажиллагаа, эрх, үүрэг хариуцлага, ёс зүй, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, зээлийн мэдээллийн сангийн тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай, Газар дээрх хяналт шалгалтаар илэрдэг нийтлэг зөрчил, анхаарах асуудал зэрэг сэдвүүд багтсан ба тус холбооны сургагч багш нар, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэргэжилтэн, Санхүүгийн зохицуулах хорооны ХЗХГ болон ХШЗГ-ын албан хаагчид хичээл заалаа.

Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд нийт хадгаламж, зээлийн хоршоодын сонгуульт гишүүд болон гүйцэтгэх удирдлагууд тус сургалтад хамрагдах юм.

БАЙР СУУРЬ



Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.ЭНХБААТАРТАЙ уулзаж тус хорооны гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар ярилцлаа.



СЗХ-ны гадаад харилцаа өнөөдөр ямар түвшинд байна вэ?

СЗХ бол банк бус санхүүгийн салбарыг бодлого, зохицуулалтаар хангаж ажилладаг байгууллага юм. Бид хөгжлийн бодлого боловсруулахад оролцож, зохицуулалтын стандарт, зарчмууд нэвтрүүлэхэд анхаарч, дагалдах хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг. Товчхондоо, манай хороог санхүүгийн зах зээл дэх шударга өрсөлдөөнийг хангаж, хөрөнгө оруулагч болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалж ажилладаг гэж ойлгож болно. Бид хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах ажлыг хяналт шалгалтаар хэрэгжүүлдэг. Ялангуяа олон нийтээс хөрөнгө босгож, бизнесийн төсөлдөө хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжүүд манай байгууллагын анхаарлын төвд байдаг.

СЗХ-ны гадаад харилцааг чиглэлээр тодорхойлж болно. Эхнийх нь санхүүгийн зах зээлийн интеграцид нэгдэх, удаах нь зах зээлийн чадавхыг сайжруулах юм. СЗХ-ны гадаад харилцааны үндсэн зорилго нь бүс нутгийн болон дэлхийн санхүүгийн зах зээлийн интеграцид гүнзгий орох явдал юм. Интеграц гэдгийг хил хязгааргүй болж байгаа энэ цагт харилцан уялдаатай ажиллаж байгаа, өндөр хөгжсөн болон хөгжиж буй (emerging market) зах зээлүүдийн нэгдэл гэж ойлгож болно. Бид тэр нэгдэл рүү илүү гүнзгий орж тэдний тоглоомд оролцох шаардлагатай юм. Бид өндөр үнэтэй мөнгө хэрэглээд байгаа асуудал ч үүнтэй холбоотой.

Манай зах зээл жижиг, дангаараа хөгжих боломж тун бага, хөгжил нь гадаадын хөрөнгө оруулалтаас ихээхэн хамааралтай. Тийм учраас гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, гаднын хөрөнгийн зах зээлийн гол тоглогчид болох, байгууллагын хэлбэрийн (institutional investor) хөрөнгө оруулагчдыг ажиллах боломж, таатай орчноор хангах асуудлууд чухал юм.

Санхүүгийн зах зээлд гадаадын компаниудын үйл ажиллагаа байгаа л бол түүнд нь таарсан зохицуулалт байх ёстой. Мөн манай бизнес эрхлэгчид гадаадын хөрөнгийн зах зээл дээр гарч, зээлийн (бонд) болон шинээр хувьцаа гаргаж хөрөнгө оруулалт босгоход таатай нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. Энэ зорилгын хүрээнд СЗХ олон улсын мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. Олон улсын хамтын нийгэмлэг буюу төрөл бүрийн мэргэжлийн байгууллагууд хөгжиж буй болон буурай хөгжилтэй зах зээлийн хөгжлийг тууштай тусалж, дэмжиж байна. Бид ч тэдэнд зүүгдэж яваад хөгжилдөө ахиц гаргачих зорилготой ажилладаг.

Та олон улсын мэргэжлийн байгууллагууд гэлээ. Энэ талаар тодруулж тайлбарлана уу?

СЗХ бол бидний нэрлэдгээр банк бус санхүүгийн салбарын зохицуулагч байгууллага юм. Үнэт цаасны зах зээл, даатгал, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг боловч банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоод СЗХ-нд

хамаарна. Бид олон улсын байгууллагуудад гишүүнчлэлтэй ажилладаг.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI), Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO), Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо (IAIS), Олон улсын хадгаламж зээлийн хоршооны зохицуулагчдын сүлжээ (ICURN) зэрэг байгууллагад нэгдэж, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож байна. Эдгээр байгууллага нь салбарынхаа хөгжлийг нэг түвшинд хүргэх нийтлэг зорилготой. Холбооны гишүүн улсууд хөгжил сайтай нь доройгоо дэмжиж, алдаа оноогоо хуваалцаад хамтдаа урагшлах, хөгжихийг зорилгоо болгосон учраас тухайн салбарын зохицуулалтын бодлого, хэрэгжилтэд шаардлагатай зарчим, стандартыг тогтоож, нэвтрүүлэх арга техник, зааврыг гаргадаг. Бид түүнээс нь суралцаж явах учиртай. Мэдээж өөрсдөө замаа олоод явж чадвал хамаагүй, гишүүн байх ч албагүй, тухайн улсын сайн дурын асуудал. Гэхдээ бид өнөөдөртөө биеэ даагаад явах чадваргүй байна.

Та Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын хуралд оролцоод ирсэн юм байна. Шинэ мэдээллээсээ бидэнтэй хуваална уу?

Үнэт цаасны зохицуулагчдын олон улсын байгууллагын 44 дэх удаагийн ээлжит чуулга уулзалт Австралийн Сидней хотод болсон. Би энэ чуулганд СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга, мэргэжилтнүүдийн хамт оролцоод

ирлээ. ҮЦХОУБ нь дэлхийн олон орны үнэт цаасны зах зээлийн зохицуулагч хороодыг нэгтгэсэн байгууллага юм. Тэд хөрөнгийн зах зээлийг жигд хөгжүүлэх, өндөр хөгжсөн зах зээлүүд бусдадаа зааж, сургаж, дагуулан алхаж өөрсдийн лигт оруулах зорилготой ажилладаг. Бид энэ байгууллагатай 2014 онд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан. Өнгөрсөн 2018 онд СЗХ-ны дарга, доктор С.Даваасүрэн тус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, дэд дарга нартай уулзаж Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн талаар дэлгэрэнгүй танилцуулж, олон улсын санхүүгийн зах зээлийн интеграцид ороход хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцсон.

Финтекийн нөлөөллөөр улам даяаршиж хил хязгааргүй болж буй энэ орчинд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хэрхэн хөгжүүлэх талаар арга зүйн туслалцаа авч ажиллахаар болсон юм. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хууль эрхзүйн орчны үнэлгээг хийж, сайжруулах шаардлагуудыг тодорхойлж, эрхзүйн орчныг нь олон улсын түвшинд нийцүүлэх чиглэлээр ҮЦХОУБ-аас бодлогын зөвлөмж гаргуулахаар боллоо.

ҮЦХОУБ нь мэргэжлийн байгууллагын хувьд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшинд үнэлгээ хийдэг юм. Манай санхүүч, шинжээчид хөрөнгийн зах зээлийг өссөн, өсөөгүй, аяндаа өсч байгаа гэх мэтээр “сонирхолтой”-гоор дүгнэдэг. Бид энэ асуудалд дэлхийн мэргэжлийн байгууллагаар дүгнэлт өгүүлэх хүсэлтээ гаргасан. Энэ ажил удахгүй эхлэх гэж байна. ҮЦХОУБ-ын Ази, Номхон далайн бүсийн улсуудын Дэд хороонд манай байгууллага байдаг бөгөөд бүс нутгийн хэмжээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийг нэг түвшинд аваачих олон ажил хийхээр төлөвлөж байна. Түүнчлэн АПЕК (Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага) гишүүн улсуудын санхүүгийн зохицуулагчдын чадавхыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлдэг. Манай улс АПЕК-ын гишүүн биш, зөвхөн ажиглагч боловч энэ хөтөлбөрт хамрагдах эхний хэлэлцээрийг хийлээ. Энэ нь манай улсын АПЕК-т элсэх хүсэлтийг дахин авч хэлэлцэхэд нэмэр болох биз ээ. Бид гадаад харилцаагаа сайжруулах зорилт тавиад олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа тасралтгүй өргөжүүлж байна.

Тухайлбал, ямар байгууллагуудтай хамтран ажиллаж байна вэ?

Манай улсын хөгжилд техникийн туслалцаа болон санхүүгийн дэмжлэг үзүүлдэг олон улсын донор байгууллага олон байдаг. Энэ байгууллагуудтай СЗХ-ны санхүүгийн зах зээлийн чадавхыг сайжруулах чиглэлээр нягт хамтран ажиллаж байна. Тухайлбал, Дэлхийн банк, ОУВС, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк, Японы Жайка, Солонгосын Койка зэрэг байгууллагыг нэрлэж болно. СЗХ дэлхийн 90 гаруй улсыг нэгтгэсэн Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн (AFI) гишүүнээр элсч, 2012 оноос хойш идэвхтэй хамтран ажиллаж байна. Энэ нийгэмлэг нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа нийгмийн эмзэг бүлэг, алслагдсан суурин газрын иргэд болон эмэгтэйчүүдийн санхүүгийн хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд бодлого гаргаж, хэрэгжүүлэхдээ гишүүн байгууллагуудаа дэмжиж ажилладаг. СЗХ нь Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн гишүүн төдийгүй бодлого боловсруулах, удирдах түвшинд нь ч ажиллаж байна. Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн ажлын зургаан хэсэгт манай мэргэжилтнүүд ажилладаг. Хорооны дарга, доктор С.Даваасүрэн энэ байгууллагын Захирлуудын зөвлөлийн гишүүнээр 2017 оноос хойш ажиллаж байна. Мөн Хүртээмжтэй даатгалын харилцан туршлага солилцох сүлжээний (MEFIN) Удирдах зөвлөлийн даргаар 2018 оноос сонгогдсон.

Япон, Солонгосын санхүүгийн зохицуулагч, хяналтын байгууллагууд манай хүмүүсийг сургах, мэргэшүүлэх тал дээр их туслалцаа үзүүлдэг. 2016 оноос хойш нийт дөрвөн хүн Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг дээр, 13 хүн Солонгосын Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага дээр богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан. Мөн ХБНГУ-ын Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага (BaFin) манай хүмүүст зориулсан сургалтыг жил бүр явуулж байгаа. Тус байгууллагаас Бонн хотод зохион байгуулсан сургалтад Хорооны зургаан ажилтан оролцож, Герман улсын зах зээл, даатгалын хяналтын чиглэлээр явуулдаг үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан.

Бид хоёр талт хамтын ажиллагааны гэрээ, хэлцлүүдийг гадаадын, манайтай ижил санхүүгийн хяналт шалгалтын

байгууллагуудтай хийж, хөрөнгө оруулалт санхүүгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хамтран ажилладаг. Одоогоор Хороо есөн улсын санхүүгийн зохицуулагч байгууллага, олон улсын мэргэжлийн холбоотой санамж бичиг байгуулан ажиллаж байна. Эдгээр санамж бичгийн хүрээнд хил дамнасан санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавин хамтарч ажиллах юм. Тухайлбал, Хонконгийн бирж дээр бүртгэлтэй компани манайд үйл ажиллагаа эхлүүлж, томоохон худалдан авалт хийлээ гэхэд нээлттэй компани учир хөндлөнгийн аудит, эсвэл биржийн хяналтынхан энэ ажиллагааны талаар илүү мэдэхийг хүснэ. Мэдээж гадаад улсаас манайд ирээд хяналт шалгалт хийх боломжгүй учраас бидэнтэй хамтарна. Эргээд бид яг ийм төрлийн туслалцаа авна. Их хэмжээний мөнгийг угаах, терроризмын санхүүжилтийн эсрэг тэмцдэг байгууллагууд ч сонирхвол мөн л бид тусална. Ийм хяналт шалгалтын орчныг бүрдүүлэхэд Хорооны гадаад харилцаа чиглэж байгаа юм.

СЗХ-ны гадаад хамтын ажиллагаа өргөжиж хэрээр бидэнд тодорхой боломж, таатай нөхцөл үүсч байгаа юм байна. Эцсийн үр дүн гэвэл?

Хэрэв манай хөрөнгийн зах зээл гадаадынхтай уялдаад бизнесийн төслүүд манайд эсвэл гадаадад мөнгө босгох боломжтой, олон төрлийн санхүүгийн хэрэгслүүд нь саадгүй арилжаалагддаг байвал бизнесийн төслийн санхүүжилтийг зөвхөн банкнаас биш олон нийт болон санхүүгийн байгууллагуудаас босгох, төрөл бүрийн хөрөнгө оруулалтын сан болон бусад хэлбэрийн санхүүгийн байгууллагууд хөгжих боломж бий болно. Үр дүнд нь өрсөлдөөний улмаас зээлийн хүү буурна, мөнгөний өгөөж нэмэгдэнэ. Энэ бол манай улстөрч, санхүүгийн мэргэжилтнүүдийн хүсээд байдаг үр дүн шүү дээ. Үүнийг бид олон улсын мэргэжлийн байгууллагуудын туслалцаатай л хийнэ. Одоо Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэгээр “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцооны төлбөрийн эсрэг нийлүүлэлт болон Т+2/3 зарчмыг нэвтрүүлэх төсөл”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах, хуулийн шинэчилсэн төсөлд эрх зүйн зөвлөмж гаргуулах ажлыг хамтран хэрэгжүүлж эхллээ. Японы Жайка

байгууллагын дэмжлэгээр хөрөнгийн зах зээлийн чадавхыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлж байна.

Харилцаагаа тэлэх, гаднын байгууллагуудтай хамтарч ажиллахад бэрхшээлтэй зүйл байдаг уу?

Гадаад харилцаагаа хөгжүүлэхэд хөрөнгө мөнгө их шаарддаг нь л их бэрхшээлтэй байдаг. Ялангуяа манай байгууллага цалингийн сангаас өөр төсөв мөнгө муутай.

Бидэнд гадаад томилолтын зардлын төсөв байдаггүй. Гадагш хурал зөвлөгөөнд оролцохдоо ихэнх тохиолдолд цаад талын зардлаар явдаг. Бид технологийн дэвшлийн эрин үед ажиллаж байгаа болохоор харилцаа холбоо харьцангуй хялбар, ажил явуулахад амар болж. Гэхдээ л гадаадад зорчих, очиж уулзах, гэрээ хэлэлцээр үзэглэх гээд олон ажил гарна. Ихэнх тохиолдолд бид хүсэлт, санал тавьдаг учраас “Та нар ирээд уулз”

гэх нь зохимжгүй байдаг. Мөнгөгүй гээд суугаад байх хэцүү. Бид яаж ийгээд зардал мөнгө олж ажлаа явуулж байна. Өндөр хөгжилтэй орнуудын санхүүгийн зохицуулагч байгууллага, донорууд бидэнд сэтгэл гарган тусалж, интеграцид орох үйл явцыг тууштай дэмжиж, олон төрлийн хурал чуулганд СЗХ-ноос оролцуулахын тулд санхүүгийн тусламж үзүүлдэг. Миний ойлгосноор тэд хэрэггүй зүйлд мөнгө зарахгүй байлгүй гэдгийг энд бас дурдмаар байна.

Байгууллагынхаа ажилтнуудын хөгжилд анхаарах боломж гардаг уу?


Хөгжлийн гол түлхүүр бол хүний хөгжил. Бид хүнээ хөгжүүлэх тал дээр онцгой анхаарч байгаа. Өнгөрсөн гурван жил орчмын хугацаанд СЗХ-ны 90 гаруй ажилтан, давхардсан тоогоор 200 гаруй удаа гадаадад томилолтоор ажилласан. Дэлхийн банк, ОУВС болон бусад хамтран ажилладаг газар

биднийг дэмжиж, ажилтнуудыг маань санхүү, эдийн засгийн мэргэшүүлэх сургалтуудад хамруулж байна. БНСУ-ын санхүүгийн үйлчилгээний агентлаг (FSS)-ын хэрэгжүүлж буй “Санхүүгийн хянан шалгагчдын түншлэлийн хөтөлбөр”-г хамрагдаж ажлын байран дээрх дунд хугацааны сургалтын гэрээг байгууллаа. Хөтөлбөрийн хүрээнд Хорооны дөрвөн ажилтан дунд, есөн ажилтан богино хугацааны сургалтад хамрагдлаа. Мөн ажлын туршлага солилцох зорилгоор тус агентлагийн мэргэжилтэн Хороон дээр ажиллахаар болсон. Бид хүмүүсээ сургах, мэргэшүүлэхталааридэвхтэй ажиллаж, боломжит сувгуудыг хайж байна. Ялангуяа финтек гэж яриад байгаа технологийн хөгжил санхүүгийн үйлчилгээнд гүнзгий нэвтэрч байгаа. Ядаж л англи хэлний дунд болон түүнээс дээш мэдлэгтэй байж дэвшилтэт технологи дээр суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хянана, зохицуулна, хөгжүүлнэ. Бид ийм л орчинд ирчихлээ.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

Хадгаламж, зээлийн хоршооны бүтэц, бүх гишүүдийн хурал

ХЗХ-г Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд дараах зохион байгуулалтын бүтэцтэй байхаар заасан.



Бүх гишүүдийн хурал ХЗХ-ны эрх барих дээд байгууллага. Энэхүү эрх барих дээд байгууллага нь тухайн ХЗХ-г үүсгэн байгуулахаас эхлээд татан буулгах хүртэлх бүхий л асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг. Тухайлбал үйл ажиллагааны тайланг нь хэлэлцэн батлах, үйл ажиллагааг зохицуулдаг үндсэн баримт бичиг болох ХЗХ-ны дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн ХЗХ-ны бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн жил тутмын үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг батлах, хадгаламж болон зээлийн бодлогыг тодорхойлдог. Түүнчлэн тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хороо, бусад үйл ажиллагааны дотоод журмуудыг батлах, гишүүдээс ирүүлсэн саналын дагуу хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах эрхийг бүх гишүүдийн хурал эдэлдэг байна. Товчхондоо бүх гишүүдийн хурал бол эрх мэдэл болон үүрэг хариуцлагын цогц тогтолцоо бөгөөд хамтын удирдлагын нэгдмэл систем юм.

Бүх гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй. Бүх гишүүдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зарлан хуралдуулдаг бол ээлжит бус хурлыг тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн шийдвэр, эсхүл нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувийн бичгээр гаргасан саналыг үндэслэн тэргүүлэгчдийн зөвлөл нь зарлан хуралдуулдаг байна.

Хэрэв ХЗХ-ны санхүү, төлбөрийн чадвар муудсан, өөрийн хөрөнгөгүй болсон тохиолдолд бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар хуульчилсан байдаг. ХЗХ нь 100 хүртэл гишүүнтэй бол бүх гишүүдийн хурал нь нийт гишүүдийн 50-аас доошгүй хувь, 101-ээс дээш бол нийт гишүүдийн 20-иос доошгүй хувь нь оролцсноор хүчин төгөлдөр болно. Гишүүдийн ирц хүрээгүй бүх гишүүдийн хурлыг ажлын 20 өдрийн дотор дахин зарлан хуралдуулах ба хурал хуралдахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө хурлын зар болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг гишүүдэд хүргэнэ.

Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар

гаргах бөгөөд оруулсан хувь хөрөнгийн хэмжээнээс үл хамааран гишүүн бүр саналын нэг эрхтэй оролцоно. Бүх гишүүдийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх ба шийдвэрт тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга гарын үзэг зурж баталгаажуулна. Харин хурлын тэмдэглэлд уг протоколыг хөтөлсөн гишүүн болон тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж, хурлаас гарсан шийдвэрүүдийг хурал хуралдсанаас хойш 30 хоногийн дотор Хороонд ирүүлэхээр холбогдох хууль, журмаар зохицуулсан байна.

ХЗХ-ны эрсдэлийн удирдлага

ХЗХ-ны эрсдэлийг удирдахад харилцан хамааралтай ажилладаг суурь 4 хүчин зүйл байдаг. Үүнд:

1. Удирдлага буюу өдөр тутмын үйл ажиллагаа

ХЗХ бүр өдөр тутмын үйл ажиллагааг удирддаг удирдлагын багтай байдаг. Энэхүү баг нь өглөө хаалгаа нээхээс эхлээд гишүүдээ хадгаламж болон зээлийн үйлчилгээ үзүүлэх зэргээр журамд заасан шаардлагын хүрээнд, тэргүүлэгчдийн зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу өдөр тутмын ажлыг авч явдаг байгууллагын нүүр царай юм. Гүйцэтгэх захирал нь өөрт ногдсон үүргийг үнэнч шударгаар гүйцэтгэхийн зэрэгцээ ажилтнуудын үйлдэл ажлыг хянаж байдаг.

2. Хяналтын зөвлөл буюу дотоод хяналт

ХЗХ нь өвөрмөц дотоод хяналтын бүтэцтэй. Хуульд заасны дагуу гишүүд дотроосоо сонгож бүрдүүлсэн зөвлөл нь ХЗХ-ны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлдэг. Хяналтын зөвлөл нь тэргүүлэгчдийн зөвлөл, зээлийн хороо болон гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хянал тавихаас эхлээд, гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, залруулахыг шаардах зэргээр ХЗХ-ны бүхий л үйл ажиллагаанд хүрч хянах өргөн хүрээнд ажиллах бүрэн эрхтэй. Хяналтын зөвлөл нь Хорооны болон хөндлөнгийн хяналтын байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангуулах үүрэгтэй бөгөөд дүгнэлтээ бүх гишүүдийн хуралд танилцуулдаг.

3. Аудит буюу хөндлөнгийн хяналт

Хөндлөнгийн хяналтын байгууллага нь ХЗХ-дын жилийн санхүүгийн тайланг хянана. Аудитын байгууллага нь ХЗХ-ны гаргаж өгсөн санхүүгийн тайланг хянаж дүгнэлт гаргахдаа тайлан дахь тоон мэдээлэл болон үзүүлэлтүүд нь зөрчилгүйг нотлох шалгалтыг хийнэ. Аудитаар хянагдсан санхүүгийн тайланг тэргүүлэгчдийн зөвлөл болон бүх гишүүдийн хуралд танилцуулдаг ба хувийг аудит Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

4. Санхүүгийн зохицуулах хороо буюу зохицуулалт

Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулах ХЗХ-дод үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно. Салбарын зохицуулах байгууллагын хувьд Хороо нь ХЗХ-доос болон аудитын байгууллагаас ирүүлэх мэдээллийг хүлээн авч хянахын зэрэгцээ ХЗХ тус бүрээр санхүүгийн шинжилгээг хийнэ. Хорооноос зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн байдалд тулгуурлан, мөн санхүүгийн болон үйл ажиллагааны байдлыг харгалзан ХЗХ-дын эрсдэлийг үнэлнэ. Эрсдэлийн үнэлгээг зайны болон газар дээрх хяналт шалгалтад үндэслэн тогтооно. Санхүүгийн зохицуулах хороо нь шалгалтын дүгнэлтэд үндэслэн шаардлагатай бол шат дараатай арга хэмжээнүүдийг гишүүдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хийнэ. Мөн Хорооноос хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааг хянаж үзэж шаарлагатай тохиолдолд үйл ажиллагааг тогтворжуулах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор заавар, журам, аргачлал боловсруулна.

ТЕХНОЛОГИЙН БУЛАН

ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН БҮТЭЭГ ДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАРТ /ФИЛИППИН УЛСЫН ТУРШЛАГААС/

Филиппин улсын хадгаламж, зээлийн хоршоодын сургалтын төвүүдийн үндэсний холбоо /NATCCO/ нь Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /ACCU/-той хамтран KAYA payment platform буюу ХЗХ-дын дундын төлбөр тооцооны системийг 2017 онд үүсгэж, 2018 оны 8 дугаар сарын байдлаар Филиппин улсын 74 ХЗХ-дыг системдээ нэгтгэн 151 агенттайгаар үйл ажиллагаа явуулж байна. Ингэснээр нэг санхүүгийн байгууллагаас гарах технологийн зардлыг бууруулж, нэгдсэн аюулгүй байдлын системийг бүрдүүлэх эхний алхмыг хийсэн байна.

Кауа нь Филиппин улсын төв банкны төлбөр, тооцооны системээс тусдаа ХЗХ-дын бие даасан төлбөр, тооцооны систем ба үүлэн тооцоололд /cloud based/ суурилсан төлбөр тооцооны платформ юм. Кауа нь ХЗХ-дын зах зээлээ өргөжүүлж, санхүүгийн үйлчилгээгээ гишүүддээ хүргэх үр ашгийг дээшлүүлэх, онлайнгаар төлбөр тооцоо хийх, вэб дээр суурилан төлбөр, мобайл банк, АТМ, дебит карт, ПОС-ын гүйлгээ зэргийг хийх боломж бүхий систем юм.



2018 оны байдлаар ХЗХ-дын гишүүд тус системээр дамжуулж дараах санхүүгийн үйлчилгээг авах боломжтой байна. Үүнд:

- Онлайн зээл төлөлт;
- Кредит карт;
- АТМ;
- Цахилгааны төлбөр төлөх;
- Даатгалын үйлчилгээ;
- Онлайн худалдаа;
- Утас, интернетийн төлбөр төлөх гэх мэт.

КАУА системд данс нээж бүртгүүлэхийн тулд ХЗХ-ны гишүүд 100 песо буюу ойролцоогоор 1.90 ам. доллар байршуулах, идэвхтэй үүрэн холбооны дугаартай байх гэсэн маш хялбар нөхцөлөөр бүртгүүлж, үйлчилгээг авах боломжтой болдог байна.

Кауа систем 2019 онд шинээр дараах төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна гэжээ. Үүнд:

- Гадаад мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа;
- Төв банкны төлбөр тооцооны системд нэгдэх;
- ПОС-ын эрх авах;
- Моргэйжийн зээлийн систем бий болгох;
- Худалдааны төлбөрийн хөгжүүлэлт;
- Байгууллагын банкны үйлчилгээг нэвтрүүлэх гэх мэт.



Зураг 1. КАУА мобайл/биржийн бус зах зээлийн гүйлгээ болон дансны тоо

ТАНИЛЦУУЛГА

Олон улсын хадгаламж зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөл (ICURN)

Олон улын хадгаламж зээлийн хоршооны зохицуулагчдын зөвлөл (ICURN) нь хадгаламж зээлийн хоршоодын хянан шалгагчдын албан бус зөвлөлийн хэлбэрээр 2007 онд үүссэн ба 2015 онд удирдах зөвлөлөөс нь бие даасан, тогтмол үйл ажиллагаатай байгууллага болгохоор шийдвэрлэснээр АНУ-д бүртгэлтэй, татвараас чөлөөлөгдсөн ашгийн бус, холбооны статустай байгууллага болсон. 9 гишүүнээс бүрдсэн удирдах зөвлөлтэйгээс гадна үйл ажиллагааг сайн дурын захирлуудын зөвлөл удирддаг. Захирлуудын зөвлөлийн бүрэлдэхүүнд Ирланд, Канад, Кени, Мексик, АНУ-ын төлөөллүүд багтсан байна.

ICURN нь хадгаламж зээлийн хоршоодыг хянахад хянан шалгагчдад учирдаг нийтлэг бэрхшээлийг давахад туслах, хянан шалгагчдын мэдээлэл солилцох, сайн туршлага судлах боломжоор хангах, сургалт болон мэдээллийн мэргэжлийн холбоо болох зорилгоор үүссэн. 6 тивийн төлөөлөл болсон 30 гаруй орны гишүүдтэй. Монгол Улс 2017 онд гишүүнээр орсон.

ICURN жил бүр бүх гишүүдийн хурлаа хийдэг бөгөөд хадгаламж зээлийн хоршооны хянан шалгагчдын хамгийн том цугларалт болдог ба хяналт шалгалтын чиг хандлага, аргачлалын сүүлийн үеийн мэдээллийг хэлэлцэх боломжийг олгодог. Жилийн хурлаар тухайн жилийн ажлын тайлангаа танилцуулахаас гадна хянан шалгагчид бүс нутгийн хэмжээнд учирч буй асуудлын талаар, идэвхтэй хяналт шалгалтын зарчмуудын талаар, цахим аюулгүй байдлын талаар, санхүүгийн хоршоодын санхүүгийн салбарын хөгжилд үзүүлэх нөлөө болон хүртээмжийн талаар, засаглалын талаар, технологид суурилсан санхүүгийн арга хэрэгслийн талаар, бэлэн мөнгөний гүйлгээг багасгах арга замын талаар зэрэг цаг үеийн асуудлуудыг хэлэлцдэг.

ICURN нь хадгаламж зээлийн хоршооны хянан шалгагч нарыг чадавхжуулахын тулд шат дараалсан сургалтыг явуулдаг байна. Энэхүү сургалт нь гишүүддээ хөнгөлөлттэй байдаг

ба санхүүгийн технологи, аюулгүй байдал, засаглал, стресс судалгаа, санхүүгийн болон эрсдэлийн шинжилгээ, бизнесийн эрх зүй, санхүүгийн болон эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх, хөрөнгө оруулалт, төлбөрийн менежмент сэдвүүдийг хамардаг байна.



Тус зөвлөлөөс 2013 оны 3 дугаар сард хадгаламж зээлийн хоршоодын засаглалыг сайжруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор хадгаламж, зээлийн хоршоодод сайн засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд мөрдөх 7 бүлэг бүхий 17 зарчмыг тодорхойлж, эдгээр зарчмуудад анхаарал хандуулахыг гишүүддээ уриалсан байдаг. Үүнд:

1–р бүлэг

Хоршооллын Олон Улсын зарчмууд

- Сайн дурын гишүүнчлэл
- Ардчилсан удирдлага, хамтын хяналт
- Эдийн засгийн тэгш оролцоо
- Хараат бус бие даасан байдал
- Гишүүдийг сургалт, мэдээллээр хангах
- Хоршоод хоорондын хамтын ажиллагаа
- Нийгмийн хариуцлага

2–р бүлэг

Тэргүүлэгчдийн зөвлөлийн үйл ажиллагаа

- Тэргүүлэгчдийн зөвлөлийн чадвар, туршлага
- Тэргүүлэгчдийн зөвлөлийн сахилга бат

3–р бүлэг

Гүйцэтгэх удирдлага

- Үйл ажиллагааны бизнесийн стратегитэй нийцсэн байдал

4–р бүлэг

Эрсдэлийн удирдлага ба дотоод хяналт

- Үр дүнтэй дотоод хяналт ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа
- Эрсдэлийг тодорхойлох ба хянах байнгын үйл ажиллагаа
- Дотоод мэдээлэл солилцооны шуурхай байдал
- Аудит болон дотоод хяналтын үр дүнтэй үйл ажиллагаа

5–р бүлэг

Нөхөн олговор, урамшуулал

- Оновчтой хяналт
- Эрсдэл хүлээх зохистой хэмжээтэй нийцсэн байдал

6–р бүлэг

Нээлттэй, ил тод байдал

- Ил тод байдлын зохистой түвшин

7–р бүлэг

Хянан шалгагчийн үүрэг

- Чиглүүлэх зөвлөгөө
- Тасралтгүй хяналт
- Мониторинг
- Шуурхай бөгөөд үр дүнтэй засаж залруулах арга хэмжээ
- Ижил төрлийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах

ICURN-ийн 2017 оны хурал Канад улсын Ванкувер хотод, 2018 онд Бүгд Найрамдах Ирланд Улсын Дублин хотод болсон бол 2019 оны хурал Америкийн нэгдсэн Улсын Чикаго хотод болно.

ӨРГӨН ДУРАН

“Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг 2019” боллоо

Санхүүгийн зохицуулах хороо “Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг-2019”-ийг амжилттай зохион явуулав.

Хэлэлцүүлэг “Бизнесийн ёс зүй ба комплаенс”, “Комплаенс ба мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг” гэсэн хоёр хэсэгтэй. Энэ үеэр оролцогчид “Санхүүгийн салбарын ёс зүй болон комплаенсын өнөөгийн байдал”, “Бизнесийн ёс зүй комплаенсын үндэс болох нь”, “Санхүүгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа”, “Олон улсын санхүүгийн хориг хэрэгжүүлэх байгууллага (FATF)-ын Ази номхон далайн бүс нутаг хариуцсан бүлгээс

(APG) өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын явц” зэрэг олон сонирхолтой илтгэлийг хэлэлцүүлээ.

Арга хэмжээг нээж СЗХ-ны дарга, доктор С.Даваасүрэн үг хэлэв. Мөн Азийн сангийн суурин төлөөлөгч Mark Koepig, СЗХ-ны Ажлын албаны дарга Б.Ариунаа, Захиргаа удирдлагын газрын дарга Б.Батзориг болон Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга Х.Батчулуун, Азийн сангийн засаглалын хөтөлбөрийн менежер А.Баянмөнх нар илтгэл тавьж, оролцогчдын санал бодлыг сонсч чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлэв.

“Санхүүгийн салбарын комплаенс хэлэлцүүлэг-2019”-д Азийн сан, Монголбанк, Сангийн яам, ГХЯ, ХЗДХЯ, ТЕГ, ОУВС, Дэлхийн банк, АХБ, ЕСБХБ, Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын ББСБ-уудын холбоо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо, Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо, Монголын банкны холбоо зэрэг олон газрын төлөөлөгч оролцож санал солилцлоо.



Цагдаагийн ажилтны мөнгө угаасан тохиолдол комплаенсын сургамж болох нь

2015 оны 2 дугаар сард АНУ-ын Нью Орлеан дахь дүүргийн шүүхээр Мексик дахь хар тамхины хамгийн аюултайд тооцогдох картелийн гишүүдийн худалдан авсан өндөр үнэтэй машинуудын зээлийн төлбөрийг ХЗХ дахь өөрийн дансаар дамжуулж, 193 мянга гаруй ам. долларын зээлийг төлсөн хэрэгт Хьюстоны цагдаагийн ажилтан буруутгагдсан.

Ноэ Хуарез 5 килограмм кокаиныг Луизана мужид тараахаар завдсан гэмт хэрэгт татагдсан. Мөн шүүхийн баримтаас үзэхэд тэрээр хар тамхины наймааг дэмжихэд галт зэвсэг авч явжээ. Хуарез нь Лос зета хар тамхины картелийн гишүүдтэй хамтран

ажиллаж байсныг нотлохын тулд холбооны товчооноос түүний Хьюстон дахь цагдаагийн ажилтнуудын ХЗХ дахь 582 сая ам. доллар бүхий дансны хуулгыг дэлгэх тогтоол гаргасан. Түүний даснаар ихээхэн хэмжээний бэлэн мөнгөний болон чекийн гүйлгээ хийгдэж байсан бөгөөд өдөрт 2-3 удаагийн бэлэн мөнгөний гүйлгээг хийсэн байжээ. ХЗХ-ны комплаенс болон зохицуулалтын шинжээчдийн үзэж буйгаар ийм хэмжээний гүйлгээ нь сэжигтэй гүйлгээний тайланд тусгагдах ёстой ажээ. Хэдийгээр Хьюстоны цагдаагийн ажилтнуудын ХЗХ нь энэ хэрэгт холбоогүй боловч ХЗХ-дод сэжигтэй гүйлгээний мэдээллийг гаргаж байхад, түүний үр дагаврын талаарх сургамж болох тохиолдол болсон гэж ХЗХ-ны комплаенс

болон зохицуулалтын шинжээчид үзэж байна.

Хьюстоны цагдаагийн ажилтнуудын ХЗХ-ны гүйцэтгэх захирал Айн В. Таллей болсон үйл явдалд тайлбар өгөхөөс татгалзсан, учир нь гишүүний дансны мэдээллийг ил болгох нь хуулиар хориглогдсон. Мөн сэжигтэй гүйлгээний мэдээлэл нь нууцад хамаардаг.

Хьюстон мужийн хар тамхины картелын дилер байж байгаад баригдаж шийтгэгдэж, улмаар засгийн газрын мэдээлэгч болсон этгээдүүдээс авсан мэдээллийн дагуу Холбооны товчооныхон Хуарезыг 2010 оны 9 дүгээр сараас эхлэн мөрдөж эхэлсэн. 2009 оны CNN-ний мэдээллээр, АНУ-ын засгийн газраас Лос Зетаг Мексик дэх хамгийн технологийн дэвшилтэт, боловсронгуй

бөгөөд аюултай картелээр нэрлэсэн. Уг картел Мексикийн армид ажиллаж байсан хүмүүсээс бүрдсэн байсан.

Хуарез өндөр чадлын зэвсэг, сум нэвтрүүлдэггүй хуяг, хууль сахиулах байгууллагын нарийн мэдээллийг картелд зардаг байсныг Луизанад хар тамхи түгээдэг Лос Зетагийн диллерүүд мөрдөгчдөд хэлсэн байдаг.

Түүнчлэн Хуарез өндөр үнэтэй 4 тээврийн хэрэгслийг Лос Зетагийн гишүүдэд хөлсөөр авч өгсөн болохыг мөрдөгчид тогтоосон. Учир нь тэд хууль ёсоор зээлдэгч байх боломжгүй. Картелийн гишүүд хар тамхины наймаанаас олсон бэлэн мөнгөөр зээлийн төлбөр хийлгэхээр Хуарезд өгсөн байсан. Тэрээр машинуудыг өөрийн болон бусад этгээдийн нэр дээр бүртгүүлж, мөн даатгуулсан байсан нь шүүхийн тэмдэглэлд үлдсэн байна.

2006 оны 8 дугаар сард тэрээр 37,145 ам. долларыг BMW 325i машиныг авахаар Хьюстоны цагдаагийн ажилтнуудын ХЗХ-оос зээлсэн. Шүүхийн баримтад авагдсанаар сар бүр төлөх хэмжээ нь 1,143 ам. доллар. Гэвч 3 жилийн хугацаатай гэрээний хуваарийн дагуу төлбөрөө төлөөгүй бөгөөд машиныг АНУ руу хар тамхийг хууль бусаар зөөвөрлөхөд ашигласан гэж шүүхийн баримтад бичигджээ.

Хуарез зээлийг 5 сарын хугацаанд төлж барагдуулсан. Заримдаа нэг өдөрт хэд хэдэн өндөр дүнтэй гүйлгээгээр зээлийн төлбөрийг хийжээ. Тухайлбал, 2006 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 1,200 ам. долларын гүйлгээг 2 удаа, 1,600 ам. долларыг 1 удаа хийж, түүнээс 6 өдрийн дараагаар дахин 1,600 ам. долларыг төлсөн. 12 дугаар сарын 01-ний өдөр 1,143 ам. долларын гүйлгээг хийж, тэр өдөртөө дахин 657 ам. долларыг төлсөн.

“Миний хувьд ийм гүйлгээ сэжигтэй санагдах байсан” гэж Вүүдбриджийн Компасс 4 ХЗХ-ны дэд ерөнхийлөгч, комплаенсын мэргэжилтэн Кристен Татлок хэлсэн. Мөн “Сэжигтэй гүйлгээний тайлан гаргах ажилд гишүүдээ мэддэг байх нь чухал бөгөөд гишүүдийн хэвийн бус үйлдэл гаргаж байгаа эсэхийг анзаарах хэрэгтэй байдаг. Цагдаагийн ажилтан зээлийн төлбөр төлөхөөр ийм өндөр хэмжээний гүйлгээнүүдийг гэнэт хийх нь жирийн бус юм. Ийм үйлдэл нь санхүүгийн байгууллагад нягталж үзэх дохиог өгөх учиртай байсан”

гэжээ. Түүнээс гадна тэрээр Хьюстоны цагдаагийн ажилтнуудын ХЗХ нь сэжигтэй гүйлгээний тайланг төрийн байгууллагад илгээсэн байж магадгүй гэж дурдсан боловч энэхүү ажиллагаа нь нууцлалтай байдгаас мэдэх боломжгүй гэж хэлсэн.

Санхүүгийн байгууллагууд өндөр дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний тайланг хэзээ илгээх ёстой талаарх асуултад харилцан адилгүй гэж Вашингтон дахь Санхүүгийн гэмт хэргийн зөвлөлийн хэвлэлийн төлөөлөгч Стив Худак хариулсан. Нэг өдрийн 10,000 ам. доллароос дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээллэх ёстой боловч сэжигтэй гүйлгээг мэдээллэх ажиллагаанд субъектив байдал ажиглагддаг болохыг Худак тайлбарласан. Бэлэн мөнгөний гүйлгээ нь хууль бус үйлдэл биш боловч сэжигтэй гүйлгээний талаар холбогдох газарт нь мэдээлж шалгах хэрэгтэй байдаг.

Хэдийгээр энэ нь хялбар сонсдох боловч зарим бэрхшээл тулгардаг. Айова мужийн Дес Мойнс хотын Полисворксын дэд ерөнхийлөгч Синди Уиллиамсын хэлснээр бол ХЗХ-д, ялангуяа жижиг ХЗХ-д мөнгө угаахтай холбоотой явдал өөрт нь тохиолдоно гэж боддоггүй. Эрүүгийн хэрэгтнүүд ихэвчлэн жижиг ХЗХ-дыг сонгодог, учир нь тэдний хяналтын бүтэц харьцангуй сул байдагтай холбоотой. ХЗХ жижиг байх нь эрсдэл багатайд тооцогдох бус харин ч эсрэгээр эрсдэлийг зарим талаараа өсгөж байдаг гэж Уиллиам тодруулсан.

Нөгөө талаар үйлчлүүлэгчтэй нүүр тулан ажилладаг ажилтнууд сайтар бэлтгэгдсэн байх ёстой. Тэдэнд аль ч гишүүнийг сайн танидаг эсэх, байнга ирдэг эсэхээс үл хамаарч бага сэжигтэй гэж байдаггүйг анхааруулж байх хэрэгтэй. Түүний олж тогтоосноор “Ажилтнууд сайн бэлтгэгдсэн эсэхээс үл хамаарч зээлтэй холбоотой сэжигтэй гүйлгээ ихэвчлэн хяналтын гадуур байдаг тул ажилтнуудад мөнгө угаах ажиллагааны олон арга хэлбэрийн талаар ойлгуулах бас нэг бэрхшээл тулгардаг.” гэсэн байна.

Санхүүгийн байгууллага сэжигтэй гүйлгээний мэдээллийг төрийн байгууллагад хүргүүлсний дараагаар хууль хяналтын багууллагууд түүнийг нягталдаг.

2007 оны 2 дугаар сарын 01-ний өдөр Хуарез 16,729 ам. долларын чекээр

BMW машины зээлийг төлсөн. Шүүхийн шийдвэрт авагдсанаар Хьюстоны цагдаагийн ажилтнуудын ХЗХ нь тэрхүү чекийн хувийг олж авч чадаагүй байна. Татлокийн хэлж буйгаар тэрхүү чекийг сэжигтэйд тооцох ёстой, түүнчлэн чекийг өөр аль нэг санхүүгийн байгууллага, эсхүл гуравдагч этгээд гаргаснаас үл хамаарч чекийг шалгах ёстой байжээ. ХЗХ түүнийг сэжигтэйд тооцож мэдээллэх учиртай. Татлокийн үзэж байгаагаар Хуарезийн чекээр хийсэн төлбөрийн гүйлгээ шалгалтын ажиллагааг эхлүүлэх, ядаж л ажилтнуудын анхаарлыг татсан байх ёстой байжээ.

Гишүүн өндөр дүнтэй мөнгөний гүйлгээ хийхэд тэдэнтэй хэрхэн харьцах талаар теллеруудыг сургахыг Уиллиамс санал болгож байна. Одоогийн байгаагаар теллерууд мөнгөний эх үүсвэрийн талаар ихэвчлэн хошигнох хэлбэрээр мэдэхийг оролддог. Зарим ХЗХ-д сэжигтэй гүйлгээний дотоод маягтай байдаг. Уг маягтад теллер, гишүүний хооронд болсон яриаг буулгадаг бөгөөд хожим комплаенсын ажилтны шалгалтад ашиглах баримт болдог. ХЗХ-д сэжигтэй гүйлгээг илрүүлэх дотоод хяналтын журам, бодлоготой байхад хянан шалгагчид дуртай байдаг талаар Уиллиамс дурджээ. Сэжигтэй гүйлгээний шилжүүлгийг тогтсон байдлаар гараар илрүүлэх нь төвөгтэй учир програм хангамж ашиглаж байхыг зөвлөж байна.

2007 онд BMW машины зээлийг төлж дуусгасны дараагаар Хуарезын зээлийн төлбөр 2008 оноос 65,941 ам. долларын Cadillac Escalade машины зээлээр үргэлжилсэн. 48 сарын хугацаатай хийгдэх хуваарьтай зээлийн төлбөрийг 4 удаагийн өндөр дүн бүхий гүйлгээг ХЗХ дахь дансаараа дамжуулан 22 сард төлж барагдуулсан. Шүүхийн баримтаас үзэхэд зээлийн төлбөрийн ижил зураглал 2007 онд 60,819 ам. долларын Cadillac Escalade машин дээр гарчээ. Зарим удаад 2,000 хүртэл ам. долларын хэмжээтэй байхад, нөгөө хэсэг нь 5,000, 6,000, 7,000 ам. долларын дүнтэй гүйлгээ хийгджээ. Энэхүү хэвийн бус, өндөр дүнтэй сарын төлбөрүүд нь холбооны мөрдөгчдийн анхаарлыг татсан байна. “Хуарезын цалингаар 7,000, 4,000, 5,000 ам. долларыг сард төлөх нь, тэр тусмаа нэг удаад 14,000 ам. долларыг төлж буй нь тун содон” гэж шүүхэд шинжээчээр оролцоходоо

тусгай мөрдөгч Ларри Жонсон хэлжээ.

АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчооны мэдээллээр Хьюстоны цагдаагийн ажилтны жилийн дундаж цалин 54,000 доллар орчим байна.

Хуарез мөн Хьюстоны шөнийн клубд хамгаалалтын ажилтнаар ажилладаг байсан бөгөөд хэд хэдэн удаагийн уулзалтаар картелийн гишүүд түүнд 2,000–5,000 ам. долларыг өгч, шүүхийн баримтад

авагдсанаар Луизанад зарагдсан хар тамхины мөнгөнөөс түүнд машины зээлийг төлөхөд өгч байжээ. Холбооны мөрдөгчдийн хэлж буйгаар Хуарезын ХЗХ дахь дансаар хийсэн зээлийн төлбөрийн түүх нь картелийн мэдээллэгчдээс авсан мэдээлэлтэй тохирсон байна.


“Хуарезын банкны дансыг шалгахад төлбөрүүд нь бэлэн мөнгөөр орж ирээд чекээр гардаг, тэр чекээр 2007 оны машины

зээлийг төлж байжээ” гэж Жонсон шүүхэд өгүүлжээ.

Хуарез нь хилээр гарч зугатах эрсдэлтэй байсан учраас АНУ-ын шүүхийн шүүгч түүнийг батлан даалтад гаргахгүйгээр хорихоор шийдсэн бөгөөд түүний дараагийн шүүх хурлын хэлэлцүүлэг 6 дугаар сарын 15-ны өдөр болно.

ОЛОН УЛСАД ХЗХ-НЫ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД BANCA DE LAS OPORTUNIDADES IV (2016–2019)

Колумб, Венесуэлийн хил дээрх орон нутгуудад санхүүгийн бүтээгдэхүүний үйлчилгээг дэмжих, хөдөө орон нутаг болон алслагдсан нутаг дахь бичил, жижиг бизнес эрхлэгчдийн хөдөө аж ахуйн бизнес эрхлэх санхүүгийн чадамжийг нэмэгдүүлэх



“Banca de las Oportunidades” төсөл нь 2008 оноос эхлэн Дэлхийн Хадгаламж Зээлийн Хоршооны Зөвлөл (ДХЗХЗ)-өөс Колумбид хэрэгжүүлж байгаа төсөл юм. Төслийн эхний үе шат буюу 2008–2010 онд ДХЗХЗ нь буурай хөгжилтэй 9 оронд хоршооны хөрөнгийг бэхжүүлэх, засаглалыг сайжруулах, хадгаламжийг нэмэгдүүлэх, бага орлоготой иргэдэд зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх талаар техникийн тусламж үзүүлж байсан юм. Харин 2-р үе шат буюу 2011–2014 онд ДХЗХЗ нь хадгаламж зээлийн хоршоодыг бэхжүүлэх, гишүүнчлэлийг нэмэгдүүлэх ажлуудыг үргэлжлүүлэн гүйцэтгэж ирсэн. 2014 оны сүүл гэхэд хадгаламж зээлийн хоршооны гишүүнчлэл 118,223 хүнээр нэмэгдэж төслийн анхны зорилго 118%-иар биеллээ олсон байна. Төслийн 3-р үе шат буюу 2013–2016 онд тус байгууллага нь 4 банк, 2 бичил санхүүгийн байгууллага,

2 хадгаламж зээлийн хоршооноос бүрдсэн нийт 8 санхүүгийн байгууллагад техникийн зөвлөмж, сургалт явуулж, Хөдөө аж ахуйн бичил зээл олгох батлагдсан аргачлалыг нэвтрүүлсэн байна. Эдгээр санхүүгийн байгууллагууд нь хөдөөгийн бичил аж ахуй эрхлэгч газар, тариалан эрхлэгчдэд хүрч чадсан бөгөөд үүний нэг илрэл нь аж ахуй эрхлэгчдийн олонх нь тогтворгүй, албан бусаар үйл ажиллагаа эрхэлж байсан бол төсөл хэрэгжсэнээр харьяа орон нутгийн захиргаанд бүртгэгдэх болсон байна.

Төслийн зорилго

ДХЗХЗ нь нийтдээ 31 хадгаламж зээлийн хоршоонд техникийн зөвлөгөө, сургалт явуулсан ба шинээр 35 бичил санхүүгийн бүтээгдэхүүнийг бий болгож, орон нутгийн иргэдэд хүргэсэн байна.

- 210,000 хүнд хүрч ажилласан бөгөөд үүнээс 100,000 хүн албан ёсны санхүүгийн үйлчилгээ авч чаддаггүй байсан байна.
- Нийт иргэдийн 70 хувийг хамарсан компани ажил зохион байгуулж анхан шатны санхүүгийн мэдлэг олгосон.
- Хөдөө орон нутгийн 5,000 иргэнд хувь хүний санхүүгийн мэдлэг олгох сургалт зохион байгуулсан.
- Хөдөө орон нутагт амьдардаг 12,200 хүнд зээл болон хадгаламжийн талаар цуврал сургалт явуулсан.
- Орон нутгийн 18 засаг захиргааны нэгжид банкны төлөөлөгчийн тоог нэмэгдүүлсэн.
- 2,000 хүнийг орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх үйл ажиллагааг сайжруулдаг байгууллагуудтай холбож өгсөн.

Орон нутаг дахь төлөөлөгч-Банкны загвар

Дээрх зорилгуудад хүрэхийн тулд ДХЗХЗ нь орон нутаг дахь төлөөлөгч, банкны загвараар дамжуулан хөдөө орон нутгийн санхүүгийн байгууллагуудтай хамтран ажилласан. Мексикт анхлан хэрэгжсэн одоо Колумб, Гайтид хэрэгжиж байгаа банкны орон нутаг дахь ажилтан загварыг тосгоны банкны систем, нийтийн банкны систем, хувь хүний бичил зээл, тосгоны хадгаламж, зээл зэрэг бичил санхүүжилтийн олон аргачлалтай хослуулан хэрэглэж санхүүгийн үйлчилгээг шууд орон нутгийн иргэд болон банкны системгүй хүн амд хүргэсэн болно. Орон нутаг дахь төлөөлөгч салбар банк болон хадгаламж зээлийн хоршоонд найдалгүйгээр тосгодоор аялж эдгээр үйлчилгээг авахад өөрийн цаг

хугацаа, мөнгөө зориулж буй үйлчлүүлэгчдээ газар дээр нь шууд үйлчилгээг хүргэж байна. Орон нутаг дахь төлөөлөгчдийг тухайн орон нутгаас сонгодог тул итгэлцлийн түвшин өндөр, өмнө нь харилцаа холбоотой байсан давуу талуудтай учир санхүүгийн байгууллагууд FARC (Fuerzas Armadas Revolucionarias de Colombia) болон ELN (Ejército de Liberación Nacional) зэрэг улс төрийн үйл ажиллагаанд өртөх өндөр эрсдэлтэй орон нутгуудад энэ загвараар дамжуулан үйлчилгээ үзүүлж байна.

Орон нутаг дахь төлөөлөгч бүр газар дээр нь орон нутгийн иргэдэд данс нээх, мөнгө хадгалах, бусад санхүүгийн гүйлгээ хийх зэрэг үйлчилгээ үзүүлэх боломжтой хөдөлгөөнт хэрэгсэлтэй байна. Эдгээр хөдөлгөөнт

хэрэгсэл нь санхүүгийн байгууллагын банкны програм хангамжид холбогдсон байх учраас үйл ажиллагааны эрсдэлийг бууруулдаг. Санхүүгийн байгууллагууд гүйлгээг хийж, эдгээр дансыг тухайн цаг үед нь шалган хянах боломжтой.

Орон нутаг дахь төлөөлөгч банкны загвар нь 262,266 гаруй бага орлоготой, банкны үйлчилгээ авч чаддаггүй хүмүүст боломжит санхүүгийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үйлчилгээ авсан иргэдийн 57 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Мөн АФРО-Колумб иргэд, уугуул иргэд, тариаланчид, байршил нь солигдсон хүмүүс, бичил, жижиг, дунд үйлдвэрлэгчид, 59,171 хүүхэд данс нээлгэсэн байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ, ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА (2017-2020)

Цахим (Дижитал) суваг ашиглан алслагдсан орон нутагт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл



Гайтигийн бүх иргэдэд эдийн засгийн өсөлтийг бий болгох нь өнөөдөр ч анхаарал татсан асуудал хэвээр байна. Гайти нь бөмбөрцгийн баруун хэсэгт орших хүн амын 59 хувь нь 2012 оны өрх гэрийн судалгааны дагуу өдрийн амьжиргааны өртөг 2.41 ам.доллар байх ёстой хэмжээнээс доогуур буюу ядуурлын түвшинд байгаа, албан ёсны салбартаа ажиллах хүчин ердөө 13 хувьтай дэлхийн хамгийн ядуу орон юм. ДХЗХЗ нь үүнийг үл харгалзан Гайтид туршлага судлан Гайтичууд орлого нь өчүүхэн бага ч хадгалах боломжтой гэдгийг харуулсан. Харин санхүүгийн үйлчилгээний хүртээмж нь бас нэгэн сорилттой тулгарч байсан нь санхүүгийн байгууллагын үйлчилгээнээс алслагдмал буюу төвлөрсөн хотуудад очих тээврийн зардал өндөр байсан явдал юм. Цаашлаад санхүүгийн байгууллагууд нь ихэнхдээ хөрвөх чадвартай актив, хөрөнгийн

дутагдалтай байсан нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, салбарт шинэ үйлчлүүлэгчийг татахтай уялдсан шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх хэрэгцээ байгааг харуулж байсан.

ДХЗХЗ нь 9 жил гаруйн хугацаанд Гайтигийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр ажиллаад байна. Энэхүү хүчин чармайлт нь Америкийн Нэгдсэн улсын Олон улсын Хөгжлийн Агентлагаас санхүүжүүлж байгаа Хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээ төсөлд биеллээ олж үр дүнтэй хэрэгжиж байна. Энэхүү хөтөлбөр нь Америкийн Нэгдсэн улсын Олон улсын Хөгжлийн Агентлагийн санхүү, эдийн засгийн хувьд амьдрах чадвар бүхий Гайти хотыг бий болгох, Гайти хотын Төв банкны хадгаламж, зээл, бусад санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй болгож санхүү, эдийн засгийн илүү оролцоог бий болгох зорилгуудыг

дэмжиж байгаа юм. АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлаг санхүүжүүлж өмнө нь хэрэгжүүлж байсан HIFIVE санхүүгийн бүтээгдэхүүний оролцооны төслийн хүрээнд олж авсан туршлагадаа тулгуурлан ДХЗХЗ нь Хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээ төслийг хоёр үндсэн зорилгын хүрээнд санхүүгийн хүртээмжийг шийдэхээр хэрэгжүүлж байна.

Зорилго 1: Хөдөө орон нутгийн иргэдэд цахим (дижитал) санхүүгийн үйлчилгээ (голчлон талбайн төлөөлөгч банкны аргачлалаар)–гээр дамжуулан санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн хүргэлтийг сайжруулах

Зорилго 2: Бичил санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоонд тулгарч байгаа хөрөнгийн бэрхшээлтэй байдалд анхаарлаа хандуулах

Зорилго 1-ийн хүрээнд ДХЗХЗ нь Латин Америкийн хэд хэдэн орнуудад хэрэгжиж туршигдсан Орон нутаг дахь төлөөлөгч банкны аргачлалыг Гайтигийн CPF, SOCO-LAVIM, LE LEVIER зэрэг хадгаламж зээлийн хоршооны холбоотой хэрэгжүүлсэн. Гайтид Гайти хэлээр Kes Pam Pi Pre'm буюу англиар “Миний хадгаламж зээлийн хоршоо надад хамгийн ойрхон” гэсэн нэрээр алдаршсан орон нутаг дахь төлөөлөгчийн банкны системийг албан ёсны санхүүгийн байгууллагын орон нутгийн төлөөлөгч моторт дугуй хөлөглөн хөдөө орон нутгуудаар

зочлон зөөврийн хэвлэгч бүхий ухаалаг гар утас, таблет ашиглан санхүүгийн үйлчилгээг хүргэж байна.

Орон нутгийн төлөөлөгчид гишүүдтэйгээ уулзаж хадгаламж цуглуулан, зээлийн өргөдөл, төлбөрийн үйл явц, шинэ хэрэглэгчдийг элсүүлэн авах зэрэг үйлчилгээ үзүүлж байна. Цахим систем ашигласан нь үйлчлүүлэгч болон санхүүгийн байгууллагуудын зардлыг бууруулж, цахимаар орлогын баримтаа авч ил тод байдлыг нэмэгдүүлж байна. Мөн ухаалаг гар утас, планшетаар дамжуулан өөрийн дансны

мэдээллийг авах боломжтой болсноор санхүүгийн байгууллагууд үйлчлүүлэгчдээ уламжлалт данснаас илүүтэйгээр хувь хүний данс үүсгэж, санхүүгийн байгууллагатай шууд харилцан зээлийн түүх бүрдүүлэх, хувь хүний хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүнийг авах боломжийг олгож байна.

Зорилго 2-ын хүрээнд ДХЗХЗ нь хадгаламж, хөрөнгө оруулалтыг хөдөлгөөнд оруулах байдлаар бичил, жижиг, дунд санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодод тулгараад байгаа хөрвөх чадвартай актив, хөрөнгийн бэрхшээлд анхаарлаа хандуулж

байна. Энэ хөтөлбөр нь үндэсний хадгаламж зээлийн хоршоодын холбоод, ДХЗХЗ-ийн салбар гишүүн болох Association Nationale des Caisses Populaires hantiennes (ANACAPH)-тай хамтран үйлчлүүлэгчээр удирдуулсан хадгаламжийн бүтээгдэхүүн, бодлого, стратегиудыг тодорхойлж, санал болгох байдлаар ажиллаж байна. Мөн ДХЗХЗ нь Тогтвортой хөрөнгө оруулалтыг бий болгох аргачлал (SIFT)-ыг турших чиглэлээр зөвлөхүүд, хөрөнгө өсгөх байдлыг дэмжих чиглэлээр Бичил санхүү, нийгмийн арга хэмжээгээр ядууралтай тэмцэх байгууллага (FINCA) нартай хамтран ажиллаж байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ, УКРАИНЫ ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД ОЛГОХ ЗЭЭЛ (2016–2020)

Хөдөө аж ахуйн бизнесийг санхүүжүүлэх төсөл

Украинд зөвхөн хөдөө аж ахуйн салбарын томоохон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид л санхүүгийн хөрөнгө оруулалтыг бүрэн дүүрэн хүртэх боломжтой бөгөөд үүний үр дүнд жижиг, дунд фирм, хувиараа бизнес эрхлэгчид санхүүгийн системийн гадна үлдэж, зээл авах боломжгүй болж байна. Энэ нөхцөл байдлаас үүдэн хадгаламж зээлийн хоршоод нь жижиг газар тариалан эрхлэгчид, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн гол санхүүжүүлэгч болдог. Гэсэн хэдий ч шинэчлэл хийлгүй 25 гаруй жил болж байгаа Украин дахь хадгаламж зээлийн хоршоод нь гишүүдийнхээ хэрэгцээг хангах чадамжаа бэхжүүлэхэд дэмжлэг туслалцаа авах хэрэгцээ бий болсон.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн зээл (CAP) төсөл нь 2016–2020 оны хооронд 4 жилийн турш хэрэгжих Америкийн Нэгдсэн улсын Олон



Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилттэй төсөл бөгөөд ДХЗХЗ хэрэгжүүлж байгаа юм. Энэхүү төслийн зорилго нь Хадгаламж зээлийн хоршоодын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үндэсний холбоодыг бэхжүүлж, гишүүдэд илүү сайн үйлчилгээ үзүүлэх, зээлийн хэрэгцээг нь хангах чадамжийг дээшлүүлэх байдлаар хадгаламж зээлийн хоршоодын хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд олгох зээлийн хүртээмжийг сайжруулахад оршино. Дээрх зорилгод

хүрэхийн тулд CAP хөтөлбөр нь олон улсын хадгаламж зээлийн хоршооны мэргэжилтэн, сайн дурын ажилтнуудын дэмжлэгтэйгээр Санхүүгийн үйлчилгээний зах зээлийн Хууль эрх зүйн Үндэсний хороо (NCSRFSM), Бүх Украины Хадгаламж зээлийн Хоршооны Холбоо (AUCUA), Украины Үндэсний Хадгаламж зээлийн Хоршооны Нийгэмлэг (UNASCU) зэрэг холбоодтой нягт хамтран ажиллаж байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ, Хамтын Хөгжлийн хөтөлбөр: Санхүүгийн бүтээгдэхүүний Технологи, Инноваци (2018–2023)

Бизнес эрхлэгчдийн санхүүгийн боломжийг нэмэгдүүлэх төсөл

Хөгжиж буй орнуудад жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зээлийн хэрэгцээг хангалттай хангаж чадахгүй байгаа нь харагдаж байна. Санхүүгийн байгууллагын нөхөрлөл, хадгаламж зээлийн хоршоод

жижиг, дунд үйлдвэрлэгчдийн зээлийг хангах чадамж, арга хэрэгсэл дутмаг байдал нь үүнд нөлөөлж байгаа юм. Хамтын Хөгжлийн хөтөлбөр: Санхүүгийн бүтээгдэхүүний Технологи, Инноваци (CDP TIFI) хөтөлбөр

хэрэгжиж байгаа зорилтот орнуудын насанд хүрэгчдийн ердөө 6–8 хувь нь зээл авах боломжтой бол дэлхийн хэмжээнд 11 хувь, АНУ-ын 34 хувь (Дэлхийн Банкны Дэлхийн санхүүгийн индекс 2017, [16](https://globalfin-</p>
</div>
<div data-bbox=)

dex.worldbank.org) нь зээл авах боломжтой байна. Эмэгтэйчүүд, залуучууд, хөдөөгийн иргэд дунджаас доогуур зээл авах чадамжтай байна.

Хамтын хөгжлийн хөтөлбөр: Санхүүгийн бүтээгдэхүүний Технологи, Инноваци (CDP TIFI) хөтөлбөр нь Америкийн Нэгдсэн улсын Олон улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа бөгөөд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн зээллэг олгох чадамжийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэйгөөр Буркина Фасо, Гуатемала, Кени зэрэг орнуудад хэрэгжиж эхлээд байна. Хөтөлбөрийг тухайн орнуудын гол байгууллага болох Баруун Африкийн Санхүүгийн байгууллагын Холбоо (Confédération des Institutions Financières de l'Afrique de l'Ouest), Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо (FENACOAC), Кенийн Хадгаламж зээлийн хоршооны нийгэмлэг (KUSCCO) –тэй хамтран



хэрэгжүүлж байна. Эдгээр хамтрагч талууд хадгаламж зээлийн хоршооны олон сая гишүүдэд техникийн тусламж дэмжлэг үзүүлж байна.

Дэлхийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зээлийн зөвлөлийн аргачлал нь дараах зорилгоор хэрэгждэг.

- Албан бус, зээлийн түүх нь баримтжаагүй, уламжлалт зээл олголтод шаардлагатай баримт бичиг, барьцааг хангах чадваргүй

жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хадгаламж зээлийн хоршоодоос зээл олгох эрсдэлийг бууруулах

- Жижиг, дунд үйлдвэрлэгчдэд зээл олгох үйл явцын зардлыг бууруулах, зээлийн үйл явцыг хялбарчлах

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан санхүүгийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанарыг сайжруулах

ХЭРЭГЛЭГЧ

ОЛОН УЛСЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ СУУРЬ ЗАРЧИМД ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ АСУУДЛЫГ ТУСГАСАН НЬ

2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараагаас санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах асуудал нь санхүүгийн системийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чухал хүчин зүйл болохыг олон улсад хүлээн зөвшөөрч цаашид хөгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байдаг.

Хэрэглэгчийн эрх ашиг хамгаалагдсан байх нь өрх гэр бүлийн түвшинд санхүүгийн бүтээгдэхүүний зардал багасч эрсдэл болон ашиг орлогын талаарх мэдээллийн хүртээмж дээшилж, иргэд олон нийтийн зүгээс санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад итгэх итгэлийг төрүүлж, хадгаламж болон урт хугацааны хөрөнгө оруулалт хийх шалтгаан болдог байна.

Монгол Улсын хэмжээнд одоогоор санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хяналт тавих чиг үүрэгтэй гурван институт ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо зэрэг банкнаас бусад санхүүгийн салбарыг

хянах зохицуулах, тус салбаруудын хэрэглэгч, хөрөнгө оруулалгчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг, Монгол банк нь банкны салбарт тавигдах шаардлагыг хянаж, зохицуулах чиг үүргийг, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар /ШӨХТГ/ нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос авч хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаа нь өөрийн зохицуулалтанд буй санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байдаг.

Банкнаас бусад санхүүгийн салбар тэр дундаа хадгаламж, зээлийн хоршооны тухайд өвөрмөц онцлогтой бөгөөд гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлдэг ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий бүхий ашгийн төлөө бус байгууллага тул санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч бусад байгууллагаас ялгагддаг.



Гишүүд нь өөрсдөө үйлчлүүлэгч тул ХЗХ санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг гишүүддээ хүргэхэд тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, эрх үүргийг нь ойлгуулах болон үнэн зөв мэдээлэлд үндэслэн ухаалаг шийдвэр гаргах боломжийг олгоход чиглэгдэх ёстой ба эрхэлж буй үйл ажиллагаа нь ашиг олохоос илүүтэйгээр гишүүдийнхээ эдийн засгийн оролцоог тэгш хангаж, тэдгээрт аливаа хэлбэрээр хүндрэл учруулахгүй байх хэрэгтэй байдаг.

ХЗХ-ны зах зээл өндөр хөгжсөн Америкийн нэгдсэн улсын туршлагаас үзэхэд тус улсын Үндэсний хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /National credit union administration/ нь 2010 онд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах газрыг /Office of Consumer Protection, OCP/ шинээр байгуулсан байна. Уг газар нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хөтөлбөр, бодлого боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг бие даасан байгууллага бөгөөд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад анхаарал хандуулах, төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, сургалт мэдээлэл хүргэх зэрэг үйл ажиллагааг явуулж байна. Мөн тус газар нь хэрэглэгчийн дуудлагын төвийг ажиллуулах, омбудсман, санхүүгийн суурь мэдээллийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэх, MyCreditUnion.gov цахим хуудсыг ажиллуулан даатгал, хадгаламж, зээлийн талаарх санхүүгийн зөвлөгөө мэдээллийг ХЗХ-ны гишүүд, хэрэглэгчдэд хүргэж санхүүгийн боловсрол олгох, тэдгээртэй холбоотой асуултад хариу өгөх тус цахим хуудсаар дамжуулан ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх зэрэг үүргийг гүйцэтгэдэг ажээ.

Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /World Council of Credit Unions, WCCU/-оос дэлхийн 160 гаруй орны ХЗХ-ны туршлагад тулгуурлан хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр дараах зарчим, стандарт, зөвлөмжийг гаргасан байна. Үүнд:

- Хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийг ил тод байлгах: ХЗХ нь гишүүддээ шимтгэл, хураамж, хүү, ногдол ашиг болон хувь хөрөнгийн талаарх мэдээллийг бичгээр буюу бусад хэлбэрээр мэдээллэдэг байвал зохимжтой;
- Тогтмол хугацаанд мэдээллэх: ХЗХ нь гишүүнд хамаарах хадгаламжийн үлдэгдэл, аливаа дансанд тооцсон хүү, ногдол ашгийн хувь хэмжээг улирал бүр мэдээллэх үүрэгтэй;
- Үнэн зөв, ойлгомжтой хэлбэрээр мэдээллэх: ХЗХ нь гишүүддээ зөв шийдвэр гаргахад тусламж болохуйц, ойлгомжтой мэдээллийг хүргэнэ;

- Зээлийн үйл ажиллагааны шударга байдал: ХЗХ нь холбогдох хууль тогтоомжийн дагуу ногдуулах хураамж, шимтгэлийг оролцуулан тооцоолсон зээлийн хүүгийн талаарх бүрэн мэдээллийг зээлдэгч гишүүнд өгнө;
- Өр, төлбөр цуглуулах цэгцтэй үйл ажиллагаа: Өр төлбөр цуглуулах ажиллагааг тогтмол, тууштай гүйцэтгэх шаардлагатай хэдий ч ХЗХ өөрөө эсхүл өөр бусад байгууллагаар дамжуулан гүйцэтгэж байгаа тохиолдолд шууд буюу шууд бус байдлаар аливаа зээлдэгчид дарамт учруулахгүй байх;
- Гишүүнтэй холбогдолтой мэдээллийг түүний зөвшөөрлөөр гаргах: Гуравдагч этгээдтэй ХЗХ-ны аливаа гишүүний мэдээллийг солилцох шаардлагатай бол тийнхүү мэдээлэл гаргаж өгөх, солилцохоос өмнө тухайн гишүүнээс зөвшөөрөл авах нь зүйтэй. ХЗХ нь гишүүдийнхээ хувийн болон санхүүгийн мэдээллийг найдвартай хадгалах, хамгаалахад чиглэсэн арга хэмжээг авна;
- Маргаан шийдвэрлэх: Хууль тогтоомжоор хязгаарлагдаагүй аливаа нэхэмжлэлийг ХЗХ-нд гаргах эрхийг гишүүддээ олгоно. Ийм үйлчилгээг ХЗХ өөрөө эсхүл, гуравдагч этгээдээр дамжуулан үзүүлнэ;
- Хэмнэлт, зээлийн ухаалаг хэрэглээний талаар зөвлөгөө өгөх: ХЗХ нь гишүүддээ хэмнэлт гаргах, зээлийг үр ашигтай зарцуулах талаар сургалт, зөвлөгөө өгнө;
- Өөрчлөлтийг шударгаар зөв хийх: ХЗХ-ны нийт гишүүдийн 30 ба түүнээс дээш хувь ХЗХ-ны хэлбэрийг өөрчлөн зохион байгуулах асуудлыг хэлэлцэхээр санал болгосон бол нийт гишүүдийн 75 хувийн саналаар тийнхүү өөрчлөн зохион байгуулах шийдвэрийг гаргах зэрэг болно.

ХЗХ-ны эдгээр зарчим, стандартыг хууль, эрх зүйн зохицуулалтад тусгаж өгснөөр хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болох ба үүнтэй уялдан ХЗХ-ны засаглал сайжрах, гишүүдийн эрх ашиг хамгаалагдах болон ХЗХ-ны хөгжлийг дэмжих гол нөхцөл болдог. Одоогийн мөрдөгдөж буй Хадгаламж,

зээлийн хоршооны тухай хуульд дээр дурдсан зарчим, стандартуудын тодорхой хэсэг нь тусгагдсан байдаг. Жишээлбэл:

Гишүүнтэй холбогдолтой мэдээллийг түүний зөвшөөрлөөр гаргах тухайд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д зааснаар ХЗХ-ны гишүүн түүнтэй холбогдох мэдээллийг тухайн гишүүн өөрөө зөвшөөрсөн болон эрх бүхий хуулийн байгууллагаас хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд задруулахгүй байхаар хуульд зохицуулсан байдаг ба энэ нь гишүүдийнхээ хувийн болон санхүүгийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах гол зохицуулалт юм.

Өөрчлөлтийг шударгаар зөв хийх тухайд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-д зааснаар нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь ХЗХ-г өөрчлөн зохион байгуулах асуудлыг хэлэлцэхээр бичгээр санал болгосон тохиолдолд бүх гишүүдийн хурлыг 30 хоногийн дотор зарлан хуралдуулахаар заасан бөгөөд мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д зааснаар хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэхээр зохицуулсан байдаг.

Дээрх зарчим, стандартыг хэрэгжүүлэхийн тулд ХЗХ-д өөрийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, ажилтнууддаа боловсрол, сургалтыг зохион байгуулж, хоршооллын мөн чанар, ач холбогдлын талаар сурталчлах, мэдээлэл өгөх замаар гишүүд ажилтныг сургалт, мэдээллээр хангаснаар ХЗХ-дын гишүүдийн санхүүгийн мэдлэг дээшлэн хадгаламж, зээлийн хоршооны салбар дахь хэрэглэгчийн эрх ашиг хамгаалагдах боломжтой байна.


ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Хөрөнгийн зах зээл

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2,456.5 тэрбум төгрөгт хүрчээ. ЗЗҮ-г өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 134.2

тэрбум төгрөгөөр буюу 5.2 хувиар буурч, 2018 оны жилийн эцсийн ДНБ-ий дүнд харьцуулахад 7.6 хувьтай тэнцсэн бөгөөд нийт ЗЗҮ-ний 90.4 хувийг 30 компанийн

үнэлгээ бүрдүүлж байна. Түүнчлэн ТОП-20 индекс өмнөх оны мөн үеийн байдлаас 195.75 нэгжээр буюу 0.93 хувиар буурчээ.



Нийт 307 хувьцаат компани бүртгэлтэй байгаа бөгөөд 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 54 үнэт цаасны компани Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК болон

“Монголын үнэт цаасны бирж” ХК-аар дамжуулан нийт 49.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдлээ. Нийт арилжааны дүнг задлан авч үзвэл, МХБ-ийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 15.3 тэрбум төгрөгийн хувьцаа, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 29.1 тэрбум төгрөгийн хувьцаа,


4.9 тэрбум төгрөгийн ЗГҮЦ, МҮЦБ-ийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 50.0 сая төгрөгийн компанийн өрийн хэрэгсэл, 9.6 сая төгрөгийн хувьцааг тус тус арилжаалав.

Даатгалын зах зээл

Тухайн зах зээлийн хэмжээг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг болох нийт хөрөнгийн хэмжээ даатгалын салбарын хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.8 хувиар өсөж 327.6 тэрбум төгрөгт хүрсэн. Даатгалын салбарт давхар даатгалын нэг компани

нэмэгдсэнтэй холбоотойгоор даатгалын салбарын хөрөнгийн бүтцэд өөрчлөлт гарсан ба давхар даатгалын нийт хөрөнгийн салбарын үзүүлэлтэд эзлэх хувь хэмжээ өнгөрсөн оны мөн үед 17.1 хувь байсан бол тайлант улирлын байдлаар 21.3 хувь болж

өслөө. Салбарын нийт хөрөнгийн 75.9 хувийг ердийн даатгалын компаниудын хөрөнгө, 2.8 хувийг урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө тус тус эзэлж байна.



Харин нийт хураамжийн орлого өмнөх оны нэгдүгээр улирлаас 8.5 хувиар өсөж 38.3 тэрбум төгрөг болов. Энэхүү өсөлтийн 98 хувийг ердийн даатгалын компаниудын нийт хураамжийн орлогын өсөлт бүрдүүлэв. Хураамжийн орлогын төвлөрүүлэлтийг авч үзвэл даатгалын зуучлагчид 7.1 тэрбум төгрөг буюу 18.5 хувийг, даатгалын төлөөлөгчид 8.7 тэрбум төгрөг буюу 22.7 хувийг бүрдүүлсэн байна.

Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал тайлант улиралд 12.6

тэрбум төгрөгт хүрч, нийт хураамжийн орлогын 32.8 хувийг эзлэв. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 8.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99 хувийг бүрдүүлж байна.

Даатгалын компаниуд өөрийн хүлээж авсан эрсдэлээ шилжүүлэх зорилгоор давхар даатгалын компанид даатгуулдаг. Манай орны хувьд дийлэнх даатгалын компаниуд гадны давхар даатгалын компанид эрсдэлээ даатгадаг ба тайлант улиралд даатгалын

компаниуд нийт 12.5 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардалтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд нийт хураамжийн орлоготой харьцуулахад 32.6 хувь байна.

Тайлант улиралд даатгалын компаниудын цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 55.4 хувиар өсөж 5.5 тэрбум төгрөг болсон байна. Салбарын өөрийн хөрөнгийн өгөөж 3.9 хувь, нийт хөрөнгийн өгөөж 1.7 хувь байна.

Банк бус санхүүгийн байгууллага


2019 оны 1 дүгээр улирлын байдлаар санхүүгийн зах зээлд нийт 539 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагууд нь нийт 10 төрлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх боломжтой байдаг. Үүнээс тайлант улиралд нийт байгууллагуудын дийлэнх нь буюу 91.5 хувь нь зээлийн үйл ажиллагааг эрхэлж, 8.5 хувь нь зөвхөн гадаад валют арилжааны үйлчилгээг дагнан эрхэлж байна.

Нийт хөрөнгийн хэмжээ 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 1.4 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 33.3 хувь буюу 348.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Активын бүтцээс харвал салбарын хөрөнгийн өсөлтийн

77.1 хувийг зээлийн өсөлт, пассивын бүтцээс харвал 53.6 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

Тайлант улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн нийт үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 268.8 тэрбум төгрөгөөр буюу 38.0 хувиар өсөж, 975.5 тэрбум төгрөгт хүрлээ. Нийт зээлийн үлдэгдлийн 84.2 хувийг иргэдийн зээл, 15.8 хувийг хуулийн этгээдийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Зээлийн чанараар ангилан харвал 86.8 хувийг хэвийн зээл, 4.1 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 9.1 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 11.1 байсан бол тайлант улиралд уг үзүүлэлт 2.0 нэгжээр буурч, зээлийн чанар сайжирсан байна.

Мөн салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирсан бөгөөд салбарын зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 1.9 дахин нэмэгдэж 263.9 мянга хүрсэн бол нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 1.2 дахин нэмэгдэж 1.7 саяд хүрсэн дүнтэй байна. Зээлийн үйлчилгээний хүртээмжийн уг өндөр өсөлт нь зээлийн нийлүүлэлтээс гадна технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрч эхэлсэнтэй холбоотой юм. Харин зээлийн бүтээгдэхүүний үнэ болох сарын жигнэсэн дундаж хүүгийн түвшин 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар 3.4 хувьтай байгаа бөгөөд хүүгийн түвшин өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.



Тайлант улиралд салбарын нийт орлого өмнөх оны мөн үеэс 32.7 хувиар өсөж, 75.4 тэрбум төгрөгт, нийт ашиг 69.9 хувиар өсөж, 31.0 тэрбум төгрөгт хүрсэн ба нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 80.5 хувь нь

34.6 тэрбум төгрөгийн ашигтай, 15.8 хувь нь 3.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, үлдсэн 3.7 хувь нь тайлант улиралд үйл ажиллагаа явуулаагүй байна. Салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох нийт

хөрөнгийн өгөөж 2.5 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 3.3 хувьтай байгаа ба өмнөх оны мөн үеэс 0.6, 0.8 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Хадгаламж, зээлийн хоршоо

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 282 ХЗХ, нийт 27 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна. ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 15.0 хувиар өсөж тайлант улиралд 66,296 боллоо.


Тайлант улиралд ХЗХ-дын нийт хөрөнгийн хэмжээ 211.7 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 31.7 хувийн өсөлтийг үзүүлжээ. Салбарын нийт хөрөнгийн 83.4 хувийг нэг тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 20 ХЗХ, 12.9 хувийг 100 саяас нэг тэрбум хөрөнгөтэй 120 ХЗХ, үлдсэн буюу 3.7 хувийг 100 саяас доош хөрөнгөтэй 142 ХЗХ бүрдүүлж байна. Салбарын активын бүтцээс харвал нийт хөрөнгийн өсөлтийн 77.8 хувийг зээлийн өсөлт, пассивын бүтцээс харвал 84.4 хувийг хадгаламжийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

Салбарын нийт зээлийн үлдэгдлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 33.6 хувиар өсөж 157.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин цэвэр зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 33.1 хувиар өсөж 152.8 тэрбум төгрөг, зээлийн эрсдэлийн сан 49.6 хувиар өсөж 4.7 тэрбум төгрөгт хүрчээ. Мөн нийт зээлийн 93.7 хувийг хэвийн зээл, 2.5 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 3.8 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 1.8 пунктээр буурч 3.8 хувьд хүрчээ.

Мөн салбарын нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 39.8 хувиар өссөн бөгөөд түүний 98.1 хувийг хугацаатай хадгаламж, 1.9 хувийг хугацаагүй хадгаламж бүрдүүлж байна. Тайлант улиралд ХЗХ-дын нийт орлого өмнөх оны мөн үеэс 29.3 хувиар өсөж 12.6 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашгийн хэмжээ 2.0 хувиар буурч 0.45 тэрбум төгрөг

боллоо. Салбарын хэмжээнд нийт 282 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаагаас 194 ХЗХ нь 1.0 тэрбум төгрөгийн ашигтай, 74 ХЗХ 0.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 14 ХЗХ ашиг, алдагдалгүй ажилласан байна.

Түүнчлэн хадгаламж, зээлийн хоршоодын өөрийн хөрөнгийн өгөөж 1.8 хувь, нийт хөрөнгийн өгөөж 0.3 хувь байгаа бол гишүүдэд олгож буй зээлийн хүүгийн орлогын нийт зээлд эзлэх хувь өмнөх оноос 0.2 пунктээр буурч 7.7 хувьд хүрчээ. Харин ХЗХ-дын үйл ажиллагааны зардал ба нийт орлогын харьцаа тайлант улиралд 26.9 хувь гарч өмнөх оноос 0.3 пунктээр буурчээ. Энэ нь ХЗХ-д 100 төгрөгийн орлого олохын тулд дунджаар 27 төгрөгийн зардал гаргаж байна гэсэн үг юм.



ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

ХАДГАЛАМЖ ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦООНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Орчин үеийн хөгжсөн санхүүгийн зах зээлийг бий болгоход санхүүгийн үйлчилгээний хэрэглэгчид гол үүргийг гүйцэтгэдэг. Нэг талаасаа хэрэглэгч олон сонголтот чанартай үйлчилгээ, бүтээгдэхүүнээс сонголт хийх хэрэгтэй бол нөгөө талаас түүний эрх нь найдвартай хамгаалагдсан байх ёстой.

Өнөө цагт хадгаламжийн баталгааны тогтолцоо (ХЗХ-г мөн хамруулсан) олон

оронд мөрдөгдөж байгаа бөгөөд энэ цуваа үргэлжилсээр байна (хүснэгт 1). АНУ, Канад, Герман, Итали, Их британи, Япон зэрэг хөгжингүй орнуудад хэрэгжүүлж байгаа ба сүүлийн 10 жилд зүүн Европын ихэнх оронд нэвтэрсэн. Энэ тоо Латин америк, ойрх дорнодод болон хойд Африкийн орнуудаар тэлж байна.

Хадгаламжийн баталгааны тогтолцоог

нэвтрүүлж буй орны тоо тасралтгүй өсөж байгаа нь энэ төрлийн хамгаалалт дэлхий дахинд санхүүгийн тогтвортой байдлыг хангах болон үндэсний хэмжээнд санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд дөхөмтэй болохыг гэрчилж байна. Зарим улсыг харахад ХЗХ-ны гишүүдийн хадгаламжийн баталгааг хариуцсан нэгээс олон байгууллага байдаг нь харагдаж байна.

Хүснэгт 1. Улсуудын хадгаламж хамгааллын тогтолцооны талаарх мэдээлэл

Улс	Хадгаламжийн баталгаа хариуцах байгууллага	Даатгуулах санхүүгийн байгууллага	Хамгаалах хэмжээ
АНУ	Холбооны хадгаламж даатгалын корпораци Үндэсний зээлийн нэгдсэн удирдлага	Арилжааны банк болон хадгаламжийн байгууллага ХЗХ	250000 USD 250000 USD
Канад	Канадын хадгаламж даатгалын корпораци	Банк, улсын тусгай зөвшөөрөл бүхий трас компани, зээлийн компани, мужийн трас болон зээлийн компани, ХЗХ, ХЗХ-дын холбоо	100000 CAD
	Санхүүгийн зах зээлийн эрх мэдэх байгууллага (Quebec)	ХЗХ, мужийн трас болон зээлийн компани	100000 CAD
	Зээл болон хадгаламжийн даатгалын корпораци (Alberta)	ХЗХ	Оруулсан хадгаламжийн хэмжээгээр
	Нью-Брансуик зээл болон хадгаламжийн даатгалын корпораци	ХЗХ	250000 CAD
	Зээл болон хадгаламжийн даатгалын корпораци	ХЗХ	250000 CAD
	Новая Шотланди зээл болон хадгаламжийн даатгалын корпораци	ХЗХ	250000 CAD
	Онтарио хадгаламжийн даатгалын корпораци	ХЗХ	100000 CAD
	Зээл болон хадгаламжийн даатгалын корпораци (Prince Edward Island)	ХЗХ	125000 CAD
Герман	Банкнудын хадгаламжийг хамгаалах сан	Хувийн арилжааны банк	100000 EUR
	Хадгаламжийн даатгалын сан	Хадгаламж болон зээлийн байгууллага	250000 EUR
Итали	Банкны хадгаламжийн сан Хоршоодын зээл болон хадгаламжийн даатгалын сан	Арилжааны банк ХЗХ	100000 EUR 100000 EUR
Япон	Хадгаламжийн даатгалын сан	Арилжааны банк, ХЗХ, ажилчдын банк (мэргэжлийн холбоодод харьяалах)	10000000 JPY
	Хөдөө аж ахуй, загас агнуурын хоршоодын хадгаламжийн даатгалын сан хамтын ажиллагааны	Хөдөө аж ахуйн хоршоо, хөдөө аж ахуйн хоршоодын ХЗХ, загас агнуурын хоршоо, загас агнуурын хоршоодын ХЗХ	10000000 JPY
Португали	Хадгалжийн даатгалын сан	Арилжааны банк	100000 EUR
	Хөдөө аж ахуйн зээлийн даатгалын сан	Хөдөө аж ахуйн хоршоо	100000 EUR
Солонгос	Хадгаламжийн даатгалын сан	Арилжааны банк, даатгалын компани, бичил санхүүгийн байгууллага, хөдөөгийн банк, хадгаламжийн банк, хөрөнгө оруулалтын банк	50000000 KRW
	Хөдөө аж ахуйн хоршооллын нэгдсэн зээл болон хадгаламжийн даатгалын сан	Хөдөө аж ахуйн хоршоо	50000000 KRW
	Хоршоодын зээлийн аюулгүй байдлыг хамгаалах сан	ХЗХ-дын хамтрал	50000000 KRW
	Зээлийн батлан даалтын сан	ХЗХ	50000000 KRW
	Загас агнуурын хоршоодын зээл болон хадгаламжийн батлан даалтын сан	Загас агнуурын хоршоо	50000000 KRW
	Ой хамгаалалын хоршоодын зээл болон хадгаламжийн батлан даалтын сан	Ойн хоршоо	50000000 KRW
Колумб	Санхүүгийн байгууллагын хадгаламжийг хамгаалах сан	Арилжааны банк	20000000 COP
	Хоршоодын батлан даалтын сан	ХЗХ	8000000 COP

Олон улсын туршлагаас харахад хадгаламж хамгааллын тогтолцооны хувьд ХЗХ-д нь банктэй дөхүү эрх зүйн статустай байна.

Хадгаламж хамгааллын тогтолцоог бүрдүүлэхэд баримтлах нэгдсэн хандлага олон улсад байдаггүй байна /хүснэгт 2/. Зарим улсуудад төрийн байгууллагуудаас

тогтолцоог нэвтрүүлж зохицуулдаг бол бусад орнуудад төрөөс хараат бус байгууллагууд бүтээж, онцгой нөхцөлд л төрөөс санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлдэг бол заримд нь төр огт оролцдоггүй байна. Санхүүгийн байгууллагууд уг тогтолцоонд заавал гишүүнчлэлээр нэгддэг нийтлэг шинж байна.

Сайн дурын гишүүнчлэл бүхий тогтолцоо нь хямралд өртөмтгий, санхүүгийн хувьд тогтворжоогүй санхүүгийн байгууллагуудын гишүүнчлэлээс хамаарч тогтворгүй байдал ажиглагддаг.

Хүснэгт 2. Хадгаламж хамгааллын тогтолцоо хөгжсөн улсуудын нөхцөл

Үзүүлэлт	Их британи	АНУ	Канад	Австрали	Ирланд
1 Тогтолцооны нэр	FSCS Санхүүгийн үйлчилгээний нөхөн олговрын хөтөлбөр (Financial Services Compensation Scheme)	NCUA ХЗХ-дын үндэсний удирдлага (National Credit Union Administration)	CUDGC ХЗХ-дын хадгаламжийн даатгалын корпораци (Credit Union Deposit Guarantee Corporation)	FCS Санхүүгийн нэхэмжлэлийн тогтолцоо (Financial Calims Scheme)	SPS Хадгаламж хамгааллын тогтолцоо (Savings Protection Scheme)
2 Байгуулсан он	2001	1974	1980	2008	1989
3 Хамгаалагдах этгээд	Банк, орон сууцны хуримтлалын хоршоо, ХЗХ, даатгалын компани, даатгалын зуучлагч, хөрөнгө оруулалтын компани, санхүүгийн зөвлөх, ипотехийн зуучлагч	ХЗХ	ХЗХ	Банк, орон сууцны хуримтлалын хоршоо, ХЗХ, даатгалын компани	ХЗХ
4 Өмчийн хэлбэр	Хараат бус сан	Хараат бус төрийн байгууллага	Альберта мужийн удирдлагаас байгуулсан	Австрали улсын засгийн газар байгуулж, Австралийн санхүүгийн салбарын зохицуулагч болох Australian Prudential Regulation Authority (APRA) удирддаг	Ирландын ХЗХ-дын лиг буюу төв ХЗХ-оос байгуулсан бөгөөд удирддаг
5 Сан бүрдүүлэх хэлбэр	Жил бүрийн хураамж	Жил бүрийн хураамж	Улирал бүрийн хураамж	Жил бүрийн хураамж	Хагас жилийн хураамж
6 Даатгалын тохиолдол	Төлбөрийн чадваргүй болох / дампуурах/	Зохицуулагч байгууллагаас үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргах	Үйл ажиллагааг зогсоох	Төлбөрийн чадваргүй болох /дампуурах/	Үйл ажиллагааг зогсоох
7 ХЗХ-нд олгох максимум нөхөн олговор	85 000 GBP	250 000 USD	Хадгаламжин хэмжээгээр	250 000 AUD	100 000 EUR
8 Төлөх хугацаа	7 өдөр, онцгой тохиолдолд 20 хүртэл хоногт	5 өдөр орчим	Мэдээлэл байхгүй	Календарийн 7 өдөр	20 хүртэл ажлын өдөр
9 Төрөөс санхүүгийн дэмжлэг олгох боломж	Боломжтой: Зээл	Боломжтой: Зээл	Боломжтой: Зээл, Альберта мужийн баталгаа	Боломжгүй	
10 Хадгаламж хамгааллын тогтолцооны чиг үүрэг:					
Нөхөн олговор олгох	+	+	+	+	+
Дампуурлын хэргийн үйл явцад оролцох	+	-	-	-	-
ХЗХ-дын үйл ажиллагаанд мониторинг хийх	-	+	+	+	+
Эрсдэлийн үнэлгээ хийх	-	+	-	+	+
ХЗХ-дод богино хугацааны санхүүжилт олгох	-	+	-	-	+

2019 ОНД БОЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

6 дугаар сарын 29

Азийн Insurtech дээд хэмжээний уулзалт, Бүгд Найрамдах Сингапур Улс

7 дугаар сарын 24–26

Олон улсын хоршоодын зохицуулагчдын сүлжээ (ICURN)–ний ээлжит чуулган АНУ

9 дүгээр сарын 5–20

Дотоод хяналтыг сайжруулах нь” семинар /Төв, хангайн бүсийн ХЗХ–д/

9 дугаар сарын 9–13

СХН–ийн ээлжит Дэлхийн бодлогын форум, Руандагийн Бүгд Найрамдах Улс

9 дүгээр сарын 26–29

Азийн ХЗХ–дын холбооны форум, Малайз улс

10 дугаар сарын 17

Олон улсын хадгаламж, зээлийн хоршооны өдөр /МОССУ евро/

10 дугаар сарын 31

Дэлхийн хуримтлалын өдөр

11 дүгээр сар 02

“Хөгжлийн төлөө хамтдаа” чуулган

11 дүгээр сар

17th annual conference of the International Association of Insurance Supervisors /IAIS/, Abu Dhabi 2019



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо